



БАЙГАЛЬ ОРЧИН  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



**ENSURE**


Эх байгальдаа Ээлтэй хандашгаая



**Төслийн нэр:** МОНГОЛЫН УНАГАН БАЙГАЛИЙН ХҮЛЦЭЛ ТОГТВОРЖИЛТЫГ ХАНГАХ НЬ

**Зөвлөх үйлчилгээний ажлын нэр:** Ногоон хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ба экосистемийн үйлчилгээг үнэлэх

**Тайлангийн нэр:** Ногоон хөгжлийн төлөвлөгөө (Баянхонгор аймаг)



Улаанбаатар, 2021

*Зөвлөх үйлчилгээний байгууллага:*

*ЖЭМР ХХК*

*Гэрээт ажлыг гүйцэтгэсэн хугацаа:*

*2019.X – 2021.IV*

*Тайланг хүлээлгэн өгсөн хугацаа:*

*2021.IV.30*

**№ ENSURE төслийн зөвлөх, менежерүүд**

- 1 З.Батжаргал
- 2 Б.Чимэд-Очир
- 3 Б.Эрдэнэбилэг
- 4 Р.Болор

**ЖЭМР ХХК-ийн зөвлөх багийн гишүүд**

- 1 Р.Оюун
- 2 Ц.Цэндээхүү
- 3 Б.Энхтуяа
- 4 С.Амгаланбаатар
- 5 Л.Оюунжаргал
- 6 С.Туяа
- 7 Г.Оюунбаяр
- 8 Л.Бадамхорлоо
- 9 Н.Энхбаяр
- 10 Б.Гантулга
- 11 Б.Ууганбаяр
- 12 Д.Ганболд
- 13 Д.Булганбаяр
- 14 А.Батзаяа
- 15 М.Дамдинпүрэвням
- 16 А.Тамираа
- 17 Б.Янжинсүрэн
- 18 Г.Доржсамбуу
- 19 П.Бат-Эрдэнэ
- 20 Э.Пүрэв-эрдэнэ
- 21 З.Сайнцаг

## Гарчиг

|  |           |
|--|-----------|
| <b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....</b>   | <b>6</b>  |
| <b>1. ОРШИЛ.....</b>   | <b>7</b>  |
| <b>2. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ.....</b>   | <b>8</b>  |
| 2.1. Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, алсын хараа 2050 .....                                       | 8         |
| 2.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль .....  | 9         |
| 2.3. Ногоон хөгжлийн бодлого .....   | 11        |
| 2.4. Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (ЗГ, 2015) .....   | 12        |
| 2.5. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, (ЗГ 2011) .....  | 13        |
| 2.5.1. Уур амьсгалын өөрчлөлтийн цаашдын хандлага, болзошгүй нөлөөлөл.....                                     | 14        |
| 2.5.2. Уур амьсгалын үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт .....   | 14        |
| 2.6. Хөгжлийн бодлого, СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТИЙН ШИНЭ ХАНДЛАГА.....  | 16        |
| <b>3. БАЙГАЛЬД ЗОХИСТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ.....</b>                      | <b>20</b> |
| 3.1. Хууль эрхзүйн орчин.....  | 20        |
| 3.1.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг.....  | 20        |
| 3.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо .....  | 20        |
| 3.3. Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл БОЛОВСРУУЛАХ.....  | 22        |
| <b>4. ТӨСЛИЙН ТАЛБАЙН СУУРЬ СУДАЛГАА, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ, НУТГИЙН ХҮН АМЫН ХЭРЭГЦЭЭТ БАЙДЛЫН СУДАЛГАА.....</b> | <b>24</b> |
| 4.1. Нийгмийн үзүүлэлт .....   | 24        |
| 4.1.1. Хүн ам.....   | 24        |
| 4.1.2. Ажил эрхлэлт болон ажилгүйдлийн түвшин.....   | 25        |
| 4.2. Эдийн засгийн үзүүлэлт .....  | 25        |
| 4.2.1. Мал, аж ахуй.....   | 25        |
| 4.2.2. Газар тариалан.....   | 26        |
| 4.3. Хөгжлийн өнөөгийн байдал.....   | 26        |
| 4.4. Дотоодын нийт бүтээгдэхүүн .....  | 28        |
| <b>5. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>                                       | <b>31</b> |
| 5.1. Хөгжлийн ба байгаль хамгаалах төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн өнөөгийн байдлын үнэлгээ .....              | 31        |
| 5.1.1. Баянхонгор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр .....  | 31        |
| 5.1.2. Баянхонгор аймгийн 2017-2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн жилийн эцсийн хэрэгжилт .....               | 32        |
| 5.1.3. Төсөлд хамрагдах сумдын хөгжлийн талаар .....   | 35        |
| 5.1.4. Ногоон хөгжлийн хөтөлбөр (НХХ).....   | 35        |
| 5.1.5. Биологийн олон янз байдлыг хамгаалах бодлого, төлөвлөлт .....   | 37        |
| 5.1.6. Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт.....                           | 38        |
| 5.1.7. Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө .....  | 38        |
| 5.1.8. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө.....   | 40        |
| 5.2. Аймаг, сумын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөр.....   | 41        |
| 5.2.1. Хөгжлийн бодлогын баримт бичгийн нийцэл .....   | 41        |

|  |           |
|--|-----------|
| 5.2.2. Асуудлын шинжлэл .....          | 44        |
| <b>6. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ .....</b> | <b>48</b> |

## Зургийн жагсаалт

|  |    |
|--|----|
| Зураг 1. Алсын хараа .....   | 8  |
| Зураг 2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн зорилго, үйлчлэх хүрээ ..                      | 10 |
| Зураг 3. Хөгжлийн бодлогын пирамид .....   | 10 |
| Зураг 4. Хөгжлийн бодлого төлөвлөлтөнд баримтлах зарчим.....   | 11 |
| Зураг 5. Дэлхийн биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээний үнэлгээний загвар, 2019 .....                  | 17 |
| Зураг 6. Дэлхийн тогтвортой байдлыг бий болгох хөшүүрэг (Transformative change) .....                                | 18 |
| Зураг 7. Экосистемийн үйлчилгээний нэр томъёоны өөрчлөлт .....   | 18 |
| Зураг 8. Зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх багц процесс .....   | 19 |
| Зураг 9. Хөгжлийн бодлого, төлөвлөлтөнд оролцогч талууд .....  | 21 |
| Зураг 10. Хөгжлийн зорилтот хөтөлбөр ба аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулах тогтолцоо ..... | 21 |
| Зураг 11. Хүн амын өсөлтийн ирээдүйн төлөв .....   | 24 |
| Зураг 12. Шилжилт хөдөлгөөн, хүн амын дундаж наслалт.....  | 25 |
| Зураг 13. Ажил эрхлэлт болон ажилгүйдлийн түвшингийн ирээдүйн төлөв .....  | 25 |
| Зураг 14. Бэлчээрийн малын өсөлтийн ирээдүйн төлөв, төрлөөр.....   | 26 |
| Зураг 15. Газар тариалангийн хураан авалт, олох орлого, ирээдүйн төлөв.....  | 26 |
| Зураг 16. Хүний хөгжлийн индекс, ирээдүйн төлөв.....   | 27 |
| Зураг 17. Аймгуудын ДНБ, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ .....  | 28 |
| Зураг 18. Аймгуудын дотоодын нийт бүтээгдэхүүн (2003-2019) .....   | 29 |
| Зураг 19. Аймгуудын нэгж талбайд ноогдох ДНБ (2003-2019) .....   | 29 |
| Зураг 20. Аймгуудын нэг хүнд ноогдох ДНБ (2003-2019).....  | 30 |
| Зураг 21. Амьдрах орчин, экосистемийн тэнцвэрийг хангахын тулд хөгжлийн төлөвлөгөөнд тусгах саналын график .....     | 46 |

## Хүснэгтийн жагсаалт

|             |   |    |
|-------------|---|----|
| Хүснэгт 1.  | Ногоон хөгжлийн бодлогын стартеги зорилт.....   | 12 |
| Хүснэгт 2.  | Ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин .....  | 12 |
| Хүснэгт 3.  | Уур амьсгалын өөрчлөлт үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт .....                              | 15 |
| Хүснэгт 4.  | Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэл .....  | 19 |
| Хүснэгт 5.  | Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг .....                                  | 20 |
| Хүснэгт 6.  | Нийгэм эдийн засгийн ерөнхий үзүүлэлт.....  | 24 |
| Хүснэгт 7.  | Аймгуудын хүний хөгжлийн индекс.....  | 26 |
| Хүснэгт 8.  | Аймгуудын хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хугацаа.....                                | 31 |
| Хүснэгт 9.  | Баянхонгор аймгийн нутаг дэвсгэр хамрагдах сав газар, зарим УННМТ-ний хугацаа .....             | 31 |
| Хүснэгт 10. | ЗДҮАХ, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, 2017 он .....                                      | 33 |
| Хүснэгт 11. | ЗДҮАХ, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, 2018 он .....                                      | 33 |
| Хүснэгт 12. | ЗДҮАХ, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, 2019 он .....                                      | 34 |
| Хүснэгт 13. | ЗДҮАХ, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, 2020 он .....                                      | 34 |
| Хүснэгт 14. | Ногоон хөгжлийн бодлогын үзэл баримтлалтай нийцтэй байдал .....                                 | 36 |
| Хүснэгт 15. | Ногоон хөгжлийн бодлогын зарчимд нийцтэй байдлын шинжлэл.....                                   | 36 |
| Хүснэгт 16. | Ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлттэй харьцуулсан байдал                                 | 36 |
| Хүснэгт 17. | Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийн хэрэгжилт .                              | 38 |
| Хүснэгт 18. | Баянхонгор аймгийн нутаг дэвсгэр хамрагдах сав газрын УННМ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө ..... | 39 |
| Хүснэгт 19. | ЗДҮАХ-д тусгагдсан авч хэрэгжүүлсэн арга хэмжээ .....   | 39 |
| Хүснэгт 20. | Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн нийцэл .....               | 41 |
| Хүснэгт 21. | Баянхонгор аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний нийцэл .....                          | 43 |
| Хүснэгт 22. | А5ЖҮЧ, хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах санал .....  | 44 |
| Хүснэгт 23. | Амьдрах орчин, экосистемийн тэнцвэрийг хангахын тулд хөгжлийн төлөвлөгөөнд тусгах санал.....    | 45 |
| Хүснэгт 24. | Баянхонгор А5ЖҮЧ-д туссан санал .....   | 46 |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

---

|         |   |
|---------|---|
| АХ5ҮЧ   | Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл          |
| БОАЖЯ   | Байгаль орчин, аялал жуулчлалын яам                   |
| БХНСАХЗ | Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал |
| БӨХ     | Байгууллагын өөрийн хөрөнгө                           |
| БЭСҮҮ   | Биологи, экосистемийн үйлчилгээний үнэлгээ            |
| ГМС     | Газарзүйн мэдээллийн систем                           |
| ГХБХБГ  | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар       |
| ДБЭСҮҮ  | Дэлхийн биологи, экосистемийн үйлчилгээний үнэлгээ    |
| ДНБ     | Дотоодын нийт бүтээгдэхүүн                            |
| ЗДҮАХ   | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр                 |
| ЖДҮХС   | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан                   |
| МУТХҮБ  | Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал       |
| МЭҮ     | Мянганы экосистемийн үнэлгээний тайлан                |
| НҮБХХ   | Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр      |
| ОНХС    | Орон нутгийн хөгжлийн сан                             |
| ОНТ     | Орон нутгийн төсөв                                    |
| СХС     | Сум хөгжүүлэх сан                                     |
| Тх      | Төсөл хөтөлбөр  |
| ТХГН    | Тусгай хамгаалалттай газар нутаг                      |
| УИХ     | Улсын их хурал  |
| МУХ5ҮЧ  | Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл     |
| ҮХГ     | Үндэсний хөгжлийн газар                               |
| ҮЧ      | Үндсэн чиглэл   |
| ХХИ     | Хүний хөгжлийн индекс                                 |
| ХЗХ     | Хөгжлийн зорилтот хөтөлбөрт                           |
| NDVI    | <i>Normalized difference vegetation index</i>         |
| PES     | Payment of Ecosystem Services                         |
| GIS     | Geographic Information System                         |
| LIS     | Land Information System                               |

## 1. ОРШИЛ

---

БОАЖЯ, НҮБХХ хамтран хэрэгжүүлж байгаа “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь” төсөл (цаашид ENSURE төсөл гэх)-ийн 4 газар, тэдгээрийг харъяалсан 4 аймаг, 13 сумын нутагт биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг үнэлэх, хөгжлийн төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газартай 2019 оны 10 дугаар сарын 24-нд байгуулсан гэрээний дагуу ЖЭМР ХХК хийж гүйцэтгэв.

Гэрээний дагуу зөвлөх баг төсөлд хамрагдсан аймгуудын Хөгжлийн ба байгаль хамгаалах төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн өнөөгийн байдлын үнэлгээ хийж, сонгосон аймаг, сумын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрийн уялдаа холбоонд дүн шинжилгээ хийлээ. Ингэхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн олон улсын жишиг арга зүйг баримтлан, урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт нь үр дүнд суурилсан байх гол шалгуур болон төлөвлөлт нь хяналт-шинжилгээ, үнэлгээтэй нягт уялдсан байх шаардлагыг харгалзан үнэлгээ хийв.

Энэхүү тайланд Засаг даргын үйл ажиллагаа хөтөлбөр, ус, цөлжилтэй тэмцэх, хог хаягдлын менежментийг сайжруулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний уялдаа холбоо мөн аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Ногоон хөгжлийн бодлого 2030-тай хэрхэн нийцэж байгаад дүн шинжлэл хийв.

Зөвлөхийн үйлчилгээг 2019.X - 2021.IV хүртэл хугацаанд хийж гүйцэтгэн, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Архангай аймгуудыг хамарсан бөгөөд энэхүү тайланд Баянхонгор аймагт хийгдсэн Ногоон хөгжлийн төлөвлөгөө боловсруулах судалгаа, үнэлгээний үр дүнг нэгтгэн харуулав.

## 2. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### 2.1. Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, алсын хараа 2050

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг 2020.05.13 өдөр Монгол Улсын их хурлын тогтоолоор батасан.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын суурь үнэт зүйлс нь эзэнт гүрнээс өнөөдрийг хүртэлх түүхэн үечлэл, алдаа оноо, үл давтагдах нүүдэлчин соёл, сэтгэлгээ, хөрвөх чадвартай Монгол хүний ирээдүйг төсөөлөх оюун санааны давхцал байх болно.

Өнгөрсөн, одоо, ирээдүйн давхцал нь оюун санаа, хурд, мөн чанар гэсэн төгс холбоост хадгалагдаж буй бөгөөд Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого нь үндэсний дахин давтагдашгүй онцлогт суурилсан, дэлхийн дэвшилтэт үзэл санаатай хослуулсан Монгол Улсын хөгжлийн загвар байх болно.

“Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого нь Монгол хүнрүү чиглэлсэн бөгөөд хүн амаа эх оронч, эрүүл чийрэг, дэлхийд өрсөлдөх боловсролтой, өмч хөрөнгөтэй болгох цогц бодлого хэрэгжүүлснээр хүн амын 80 хувийг дундаж давхарга руу оруулахаар зорилго тавьсан байна.

Зураг 1. Алсын хараа



Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын эрхэм 9 зорилго:

1. Үндэсний нэгдмэл үнэт зүйл “Үндэсний нэгдмэл үнэт зүйлийн гүн ухамсар дархлаатай улс үндэстэн болно”.
2. Хүний хөгжил “Монгол Улсын Хүний хөгжлийн индексийг 0.9-д хүргэж, аз жаргалын индексээр дэлхийн эхний 10 орны тоонд багтана”.
3. Амьдралын чанар ба дундаж давхарга “Сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг 2050 он гэхэд нийт хүн амын 80 хувьд хүргэнэ”.



4. Эдийн засаг "ДНБ 6.1 дахин нэмэгдэж нэг хүнд оногдох ДНБ 3.6 дахин өсөж, 15,000 ам.долларт хүрч, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын босгыг давна".
5. Сайн засаглал "Тогтвортой засаглал тогтож, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно".
6. **Ногоон хөгжил "Ногоон хөгжлийг эрхэмлэн байгаль орчны тогтвортой байдлыг хангана"**.
7. Амар тайван, аюулгүй нийгэм "Үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах гадаад дотоод таатай орчин бүрдэнэ".
8. Бүсчилсэн хөгжил "Бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, өрсөлдөх чадвартай улс доторх бүсүүдийг хөгжүүлнэ".
9. Улаанбаатар ба дагуул хот "Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй хот болгон хөгжүүлнэ". Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын гол цөм нь Монгол хүн байж хөгжлийн бодлогын зорилго бүр Монгол хүний сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд чиглэх болно.

---

## 2.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль

---

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг 2020.05.07 өдөр Монгол Улсын их хурлын тогтоолоор батасан. Энэ хуулиар Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, мэдээлэх, хөгжлийн бодлого төлөвлөлтийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцаа зохицуулагдаж байна.

Монгол улсын хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах 15 зарчмыг баримтлана гэж заасан байна:

1. Үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;
2. Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх;
3. Нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
4. Тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх;
5. Тэнцвэртэй байх;
6. Нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх;
7. Ил тод, нээлттэй байх;
8. Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
9. Зорилго, зорилт хэмжигдэхүйц байх;
10. Шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх;
11. Төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх;
12. Төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах;
13. Бүх талын оролцоог хангасан байх;
14. Төр-хувийн хэвшлийн түншлэлийг зохистойгоор хангах;
15. Оролцогчдын хариуцлагын зарчим.


Зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулах аймгуудын хөгжлийн төлөвлөгөө нь дунд (2020-2030 он), урт (2030-2050 он) хугацаатай байна. Сумын хөгжлийн бодлого, төлөвлөгөөг боловсруулахдаа дээрх хуулинд өгөгдсөн нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

- 4.1.1. Улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд, урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр


дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан эрх бүхий этгээдээс баталсан баримт бичгийг;

- Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангах, үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 17.3. Сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжийн саналыг авч, Засаг даргыг томилогдсоны дараах нэг сарын дотор багтаан боловсруулна.

Зураг 2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн зорилго, үйлчлэх хүрээ



Зураг 3. Хөгжлийн бодлогын пирамид



Эх сурвалж: ҮХГ, А. Мөнхболд доктор/ph.d/, дэд профессор Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, 2019



### 2.3. Ногоон хөгжлийн бодлого

Судалгаанд Монгол улсын Ногоон хөгжлийн бодлого (УИХ, 2014)-д тодорхойлсон БЭСҮҮ болон ногоон хөгжилтэй холбоотой үндсэн нэр томъёог ашигласан. Энэ бодлого хэрэгжвэл 2020 онд ногоон хөгжлийн үндэс тавигдаж, 2021-2030 онд ногоон хөгжилд шилжсэн байна.

#### Үндсэн ухагдахууны тодорхойлолт

- *Ногоон хөгжил*: байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай ашиглах, экосистемийн үйлчилгээг тэтгэх, хүлэмжийн хий, хаягдлыг бага байлгах, нийгмийн оролцоог хангаж ядуурлыг бууруулах **хөгжлийн загвар**.
- *Экосистемийн үйлчилгээ*: **байгалиас заяасан** хүнс, түүхий эд, нөөцөөр хангах, уур амьсгал, орчны эрс өөрчлөлтийн нөлөөг зохицуулах, хүний амьдралыг тэтгэх, оюуныг сэргээх **үр өгөөж**.
- *Экосистемийн үйлчилгээний төлбөр*: экосистемийн үйлчилгээг хүртэгч болон уг үйлчилгээг тогтвортой хадгалахад хувь нэмрээ оруулагчийн хооронд бий болгох **төлбөрийн зохицуулалтын механизм**.

Экосистемийг Ногоон хөгжлийн бодлогод тодорхойлоогүй байна. Экосистемийг “Монгол хэлний их тайлбар толь”-нд “Орчин, нөхцөл байдлын хэмжээгээрээ бие биеэсээ хамааран орших биологийн объектууд” гэж тайлбарласан бол “Википедиа” нэвтэрхий толинд “Өөр хоорондоо тэжээлийн хэлхээгээр холбогдсон амьд биес, тэдгээрийн бодисын солилцоо энергийн хувиралд оролцох орчин тойрны амьгүй бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгдмэл тогтолцоо” гэж нилээд ялгаатай тодорхойлсон байна.

Цаашдаа төсөлд хамрагдах нутаг, аймаг, сумдын янз бүрийн мэргэжил, боловсрол, мэдлэг бүхий хүмүүстэй харилцах, хамтран ажиллах тул экологи, экосистем зэрэг мэргэжлийн нэр томъёоны утга, ялгааг Монгол үгээр оновчтой илэрхийлж, хэрэглэж хэвшүүлэхийг зорьсон. Тухайлбал, экологийг сав шим (амьтай, амьгүй, физик, хими, биологи, нийгэм, эдийн засаг)-ийг судлахуй ухаан, экосистемийг сав шимийн тогтолцоо, экосистемийн үйлчилгээг байгалийн өгөөж, хишиг гэх мэтээр товч, энгийнээр нэрлэхийг санал болгож байна.

## Ногоон хөгжлийн бодлогын стратеги зорилт

Ногоон хөгжлийн бодлогод 6 стратеги зорилт (Хүснэгт 1), тэдгээрийг хэрэгжүүлэх 52 арга замыг тусгасан бөгөөд үүнд байгалийн нөөц, экосистемийн тэнцвэр, ногоон эдийн засаг, ахуй соёл, үйлдвэрлэл, үйлчилгээ, шинжлэх ухаан, технологи, хөрөнгө оруулалт гээд энэ зөвлөх үйлчилгээгээр хийх БЭСҮҮ, хөгжлийн төлөвлөлтөд чиглэл өгөх бүхий л зүйлс орсон байна. Мөн 2020, 2030 онд хүрэх түвшнийг тодорхой заасан 14 шалгуур үзүүлэлт байна (Хүснэгт 2).

### Хүснэгт 1. Ногоон хөгжлийн бодлогын стратеги зорилт

| Ногоон хөгжлийн бодлогын стратеги зорилт |  |
|--|--|
| 1  | Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал, хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ.   |
| 2  | БО-г хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.  |
| 3  | Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. |
| 4  | Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.  |
| 5  | Байгальд зохицсон ахуй, соёлын үнэт зүйлсийг хөгжүүлж, боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгоно.   |
| 6  | УАӨ, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхад нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ.   |

### Хүснэгт 2. Ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

| Шалгуур үзүүлэлт  | 2020 | 2030 |
|---|------|------|
| 1 Сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь                                    | 20   | 30   |
| 2 Барилгын дулааны алдагдлын бууралт, хувь                              | 20   | 40   |
| 3 Хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээ, хувь                       | 20   | 40   |
| 4 Ногоон хөгжилд зарцуулах зардлын ДНБ-нд эзлэх хувь                    | 2    | 3    |
| 5 ШУТ-ийн судалгаанд зарцуулах зардлын ДНБ-нд эзлэх хувь                | 2    | 3    |
| 6 Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь                     | 20   | 30   |
| 7 Тусгай хамгаалалттай газар нуггийн хэмжээ, хувь                       | 25   | 30   |
| 8 БО хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хувь       | 20   | 30   |
| 9 Нийт газар нутагт ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь                | 8.5  | 9    |
| 10 Баталгаат ундны усаар хангагдах хүн амын эзлэх хувь                  | 80   | 90   |
| 11 Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдах хүн амын эзлэх хувь | 40   | 60   |
| 12 Ядуурлын түвшин  | 24   | 15   |
| 13 УБ, бусад суурин газрын ногоон байгууламжийн талбайн эзлэх хувь      | 15   | 30   |
| 14 ДНБ-нд ХАА, боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь                    | 28   | 30   |

Эх сурвалж: Ногоон хөгжлийн бодлого, УИХ, 2014

## 2.4. Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (ЗГ, 2015)

Монгол улс биологийн олон янз байдлын тухай олон улсын конвенцид 1973 онд нэгдэн орсон бөгөөд 2015 онд МУЗГ Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийг баталсан. Энэ хөтөлбөр нь биологийн олон янз байдлыг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, генетик нөөцийн ашиглалтаас олох ашгийг шударга, тэгш, хүртээмжтэй хуваарилахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, олон улс, бүс нутгийн хэмжээнд санаачлагатай хамтран ажиллах, үндэсний бодлого, үр ашигтай зохицуулалтыг

хэрэгжүүлэхэд чиглэсэн. БЭСҮҮ ба хөгжлийн төлөвлөгөөний ургамал, амьтантай холбоотой зүйлсийн агуулга, чиглэл, шалгуур үзүүлэлтийг энэхүү хөтөлбөртэй уялдуулна.

Уг хөтөлбөрт “Биологийн олон янз байдал” гэдгийг дэлхий дээрх амьд бие организмын олон янз байдал, тухайлбал хуурай газар, далай тэнгис, усан орчны экосистем, экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох амьтан, ургамал зэрэг амьд биет болон тэдгээрийн генетикийн олон янз байдлыг багтаасан нийлмэл ойлголт гэж тодорхойлсон.

Энэ хөтөлбөрт биологийн янз байдлын талаар 4 тэргүүлэх чиглэл, 14 зорилго, 29 зорилтыг дэвшүүлж 14 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна. Биологийн олон янз байдал нь экосистемийн бүрэлдэхүүн хэсэг тул уг хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл, зорилго, зорилтод экосистемтэй холбоотой олон зүйл орсон байна. Мөн олон улсад баримталж байгаа “Айчи”-гийн зорилтуудыг (Биологийн олон янз байдлын тухай конвенц) Монгол орны байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлог, хэрэгцээтэй уялдуулан хүрсэн үр дүнгээ дэлхий нийтийн зорилттой харьцуулан тайлагнах суурь мэдээ, шалгуур үзүүлэлттэй байх зарчим баримталсан нь ДБЭСҮҮ (IPBES, 2019)-ийн агуулга, аргачлалтай нийцтэй байгаа тул үүнийг бид үнэлгээ, төлөвлөлтийн ажилдаа чиглэл болгосон.

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015)-ийн тэргүүлэх чиглэл

1. Биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглах талаарх шийдвэр гаргарч, олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх
2. Биологийн олон янз байдлын нөөцийн талаарх шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан зохистой ашиглах болон хамгааллын бодлогыг бий болгон хэрэгжүүлэх
3. Биологийн олон янз байдлын тогтвортой ашиглах нөхцөлийг хангах
4. Биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг хамгаалах, ашиглах бодлого, эрх зүйн орчныг сайжруулах

---

## **2.5. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, (ЗГ 2011)**

---

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-ын Монгол Улсын хөгжлийн 5 дугаар тэргүүлэх чиглэлийн "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга чадавхыг чадавхыг бий болгох, экосистемийн тэнцвэрт байдлын алдагдлыг зогсоох, хамгаалах замаар тогтвортой хөгжлийн орчин бий болгоно" гэсэн заалт нь "Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр" /цаашид хөтөлбөр гэх/-ийг боловсруулах гол үндэслэл болж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр нь байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтөд, эдийн засаг, нийгмийн салбарыг нийцүүлэн хөгжүүлэх, түүний эмзэг байдал, эрсдэлийг бууруулах, хүлэмжийн хийн ялгаралтыг багасгах замаар үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх, ногоон эдийн засгийн хөгжил, өсөлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Уг хөтөлбөр нь 5-н тэргүүлэх чиглэлийн хүрээнд 34 зорилго дэвшүүлж зорилго тус бүрээр арга хэмжээнүүдийг тодорхойлсон байна. Уг хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл, зорилго, зорилтод экосистемтэй холбоотой олон зүйл орсон байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн гол шалтгаан нь хүний үйл ажиллагааны улмаас агаар мандалд ялгарч байгаа хүлэмжийн хий юм.

Хүлэмжийн хий гэж хэт улаан туяаг шингээн авч буцаан туяаруулах шинж чанартай байгалийн буюу хүний үйл ажиллагааны гаралтай хийн мандлын бүрэлдэхүүн хэсэг юм. Үүнд нүүрсхүчлийн хий (CO<sub>2</sub>), метан (CH<sub>4</sub>), азотын хүчил (N<sub>2</sub>O), ус фторт нүүрстөрөгчүүд (HFCs), перфторт нүүрстөрөгчүүд (PFCs), гексафторт хүхэр (SF<sub>6</sub>) зэрэг хий орно. Хүний үйл ажиллагааны улмаас агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламж ихсэж байгаа нь орчин үеийн уур амьсгалын өөрчлөлтийн гол шалтгаан болж байна.

### **2.5.1. Уур амьсгалын өөрчлөлтийн цаашдын хандлага, болзошгүй нөлөөлөл**

Эрдэмтдийн тооцоогоор дулааралт нь хуурайшилт, цөлжилтийг улам идэвхжүүлж, гадаргын ууршилт нь хур тунадасны бага хэмжээний өсөлтөөс даруй 6-10 дахин их байхаар байна. Дулааралтын улмаас цэвдэг, өндөр уулын мөстөлийн хайлалт улам идэвжих болно. Цамбагарав уулын мөстлийн зузаан 2040 оны үед 50 м-ээр, 2050-2060 оны үед 100 м-ээр, 2070-2080 оны орчимд 200 м-ээр тус тус хайлах төлөвтэй байна. Цэвдэгт мандлын элэгдлийн улмаас Алтай, Хангайн нурууны ар хажуугаас эх авдаг голуудын усны нөөц зууны эхний хагаст нэмэгдэх магадлалтай боловч цаашид багасах болно.

Зундаа их халж хуурайшин жилийн хүйтэн улиралд ордог цасны хэмжээ нэмэгдсэнээр зудын эрсдэл улам нэмэгдэж, бэлчээрийн мал аж ахуйг эрхлэх байгалийн нөхцөл нэн хүндэрч болзошгүй. Газар тариалангийн төв бүсэд улаан буудайн ургац 2011-2030 онуудад дунджаар 15 хувиар буурч болзошгүй байна. Дулааралтын улмаас монгол оронд урьд өмнө ажиглагдаж байгаагүй дулаан орны шинэ өвчин дамжуулагчид тархах, хүнсний аюулгүй байдал алдагдаж, улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх магадлал өндөр байна.

Уур амьсгалын дулаарах үед зарим нутагт дулаан бүсийн ургамал тарих, газар тариаланд өмнө нь ашиглах боломжгүй байсан хүйтэн уур амьсгалтай зарим нутгийг эзэмших, байшин барилгын халаалтын хугацааг богиносгох, ханын зузааныг нимгэлэх боломж бүрдэх, зарцуулах цахилгаан эрчим хүч, дулааныг хэмнэх, гол мөрөн, нуурын мөсөн бүрхүүлтэй байх хугацаа богиносгох зэрэг эерэг нөхцөл бүрдэх боловч манай орны хувьд сөрөг үр дагавар нь эрс давамгайлахаар байна.

### **2.5.2. Уур амьсгалын үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт**

Уур амьсгалын үндэсний хөтөлбөрийг 2011-2021 оны хугацаанд 5 стратегийн зорилтийн хүрээнд 2 үе шаттай хэрэгжихээр төлөвлөсөн. Нэгдүгээр үе шат буюу 2011-2016 онд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний чадавхыг бэхжүүлж, эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог бүрдүүлэн, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хоёрдугаар үе шат буюу 2017-2021 онд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох боломжит арга хэмжээг хэрэгжүүлэх, хүлэмжийн хийн ялгаралтын өсөлтийг сааруулах үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх эхлэл тавигдахаар байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратегийн зорилт, тус бүрийн шалгуур үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэнд оруулав.

Хүснэгт 3. Уур амьсгалын өөрчлөлт үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

| № | Стратегийн зорилт   | Шалгуур үзүүлэлт  |  |
|---|---|---|--|
|   |   | I үе шат  | II үе шат  |
| 1 | Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог бүрдүүлэх  | Холбогдох хуулийг шинээр батлуулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулна.<br>Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахад чиглэсэн хөндлөнгийн аудитын тогтолцоо бүрдүүлэх бөгөөд эрчим хүч хэмнэлтийн шинэ стандартыг батлуулна.<br>Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар үндэсний болон салбар дундын зохицуулалтыг хариуцсан нэгж байгуулна.  |  |
| 2 | Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлж, байгаль орчны тэнцвэрт байдлыг ханган, эдийн засаг, нийгмийн эмзэг байдал, эрсдэлийг үе шаттайгаар бууруулах                               | 1. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүний эрүүл мэндэд учирч болох аюул, эрсдэлийг эртнээс сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чадамж бүрдэж эхэлнэ. 2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаар эрүүл мэндийн салбарын стратеги батлагдана. 3. Усны сав газрын менежментийг нэвтрүүлсэн голын тоо 3-т хүрнэ. Хөв цөөрмийн тоо, 2010 оныхоос 10-25 хувиар нэмэгдэнэ. 4. Ойжуулсан талбайн хэмжээ 2010 оныхоос 30.0 мян.га нэмэгдэнэ. 5. Үндэсний хэмжээнд нийт 4-6 газарт хүлэмжийн хий шингээх чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжинэ. | 1. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүний эрүүл мэндэд учирч болох аюул, эрсдэлийг эртнээс сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чадамж бүрдэнэ. 2. Усны сав газрын нэгдсэн менежмент хэрэгжсэн голын тоо 7-д хүрнэ. 3. Хөв, цөөрмийн тоо 2010 оныхоос 20-30 хувиар нэмэгдэнэ. 4. Ойжуулсан талбайн хэмжээ 2010 оныхоос 60.0 мян.га нэмэгдэнэ. 5. Үндэсний хэмжээнд нийт 10-15 газарт хүлэмжийн хий шингээх чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжинэ. |
| 3 | Байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх замаар хүлэмжийн хийн ялгаралтыг үе шаттайгаар бууруулж, карбон багатай эдийн засагт шилжих эхлэлийг тавих | 1. Төвийн эрчим хүчний нэгдсэн системийн цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн жишмэл түлшний хувийн зарцуулалт 2010 оныхоос 10-20 гр.ж.т/кВт.ц-аар буурна. 2. Эрчим хүчний балансад сэргээгдэх үүсвэрийн эзлэх хувь 10.0 хувьд хүрнэ. Дулааны хэрэглээ 25 хувь хүртэл буурна.   | 1. Төвийн эрчим хүчний нэгдсэн системийн цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн жишмэл түлшний хувийн зарцуулалт 2015 оныхоос 15 гр.ж.т/кВт.ц-аар буурна. 2. Дулааны үйлдвэрлэлийн түлшний хувийн зарцуулалт улсын хэмжээнд 2015 оныхоос 25 кг.ж.т/Гкал-аар буурна.  |
| 4 | Уур амьсгалын ажиглалтын сүлжээг өртгөтгөх, технологийн шинэчлэл хийх, судалгаа шинжилгээ, үнэлгээний ажлыг өргөжүүлэх, боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх   | 1. Уур амьсгалын ажиглалтын сүлжээний зохистой бүтцийг бий болгож цаг уурын өртөө, харуулын 60-аас багагүй хувь нь автомат ажиллагаанд шилжиж хэмжилтийн тасралтгүй ажиллагааг хангана. 2. Төв, орон нутгийн хэмжээнд цаг агаарын зураг мэдээлэл дамжуулах ажиллагаанд шилэн  | 1. Уур амьсгалын ажиглалтын сүлжээг дэлхийн стандартад хүргэж ус, цаг уурын өртөө, харуулыг автомат станцаар бүрэн тоноглоно. 2. Байгалийн аюул гамшиг, уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн хандлагыг тооцоолоход шаардагдах  |

|   |   |  |  |
|---|---|--|--|
|   |   | кабель ашиглах технологид шилжинэ.<br>3.Гадаргын усны хяналтын сүлжээг 30 ажиглалтын нэгжээр өргөтгөж, гүний усны 200-гаас доошгүй цэг бүхий сүлжээтэй болсон байна.<br>4.Уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээг 5 жил тутамд шинэчлэн хийж, түүний байгаль орчин, эдийн засаг, нийгмийн салбарт нөлөөлөх байдал, эрсдэлийн үнэлгээний чанар сайжирна.   | супер компьютер ашиглаж эхэлнэ.<br>3. Улсын нийт нутгийг доплерийн радарын сүлжээнд хамруулсан байна<br>4.Уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээнд тулгуурлан дасан зохицохуйн бодлого, арга хэмжээний хувилбар гарч түүнийг нь улсын эдийн засаг, нийгмийн дунд, урт хугацааны төлөвлөлтөд тусгадаг болно. |
| 5 | Олон нийтийг уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллээр хангах уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагаа, арга хэмжээнд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлэх | 1.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах талаар олон нийтийн мэдлэг, мэдээллийг илэрхийлэх нийгмийн судалгааны үр дүнд ахиц гарна.<br>2.Хэвлэн нийтлүүлсэн ном товхимол, гарын авлага, бусад материал, зохион байгуулсан сургалт семинарын тоо нэмэгдэнэ.<br>3.Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээнд оролцсон, холбогдох төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын хүрээ өснө. |  |

## 2.6. Хөгжлийн бодлого, СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТИЙН ШИНЭ ХАНДЛАГА


Шинжлэх ухаан, технологийн дэвшил, уур амьсгал, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн харилцааны асар их өөрчлөлт хувьслын энэ цаг үед тив дэлхий, улс орнууд урьд өмнө байгаагүй шинэ, тодорхойгүй нөхцөл байдал, сорилттой тулгарч, ирээдүйд оршин тогтнох, хөгжин дэвших гарц, шийдэл олох эрэл хайгуул, үйл ажиллагааг өрнүүлж байна. Энэ талаар дэлгэрэнгүй судалгаа, үнэлгээг Дэлхийн БЭСҮҮ-д (IPBES, 2019) хийсэн бөгөөд үүнд үнэлгээнээс гадна тогтвортой хөгжил, байгаль хамгаалал, сайн сайхан амьдралын төлөөх бодлого, хөтөлбөр, стратеги төлөвлөлтийг шинжих, хөгжлийн гарц, шийдлийг тодорхойлох шинэ хандлага, арга ухаан, хэрэгсэл ашиглах санал дэвшүүлж тодорхой загваруудыг гаргасан байна. Үүнээс бид суралцаж, БЭСҮҮ болон аймаг, сумын хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг судлах, үнэлэх зорилго, чиглэл, аргачлалын эхний хувилбарыг дараах байдлаар гаргав. Үүнд:

1. БЭСҮҮ ба хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний судалгаа, үнэлгээнд дэлхийн үнэлгээний жишгээр “байгаль-байгалийн өгөөж-сайн сайхан амьдрал” загвар (Зураг 5), биологи, экосистем, хөгжлийн асуудал, гарц, шийдлийг дангаар нь биш уялдаа холбоонд нь авч үзэх “nexus thinking”, хүн байгалийн хамтын үйлдвэрлэл “nature-people co-production”, дорвитой өөрчлөлт хийх “transformative change”, хөшүүрэг “leverage” (Зураг 6), нийлмэл системийн онол “complexity theory”, өгөө авааг тэнцүүлэх “trade-offs”, алсын зайнаас хамтрах “telecoupling” зэрэг шинэлэг арга ухаан хэрэглэх, биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг нэгтгэн байгалийн өгөөж гэж нэрлэх. (Зураг 7);
2. Зөвлөх үйлчилгээний ажлыг үнэлгээ, төлөвлөлт хийх, орон нутгийн удирдлага, хүмүүсийн оролцоог хангах, чадавхыг бэхжүүлэх 3 бүлэг ажлыг 15 багц процессоор хот, хөдөөд ялгаатай хэрэгжүүлэх (Зураг 8);




3. Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний агуулгыг холбон бодох аргаар (nexus thinking) дараах 5 чиглэлээр шинжих, үнэлгээ өгөх, боловсруулах (Хүснэгт 4);
- Хуурай газар, ус, эрэг орчмын экосистемийг доройтуулахгүй, тэнцвэрийг алдагдуулахгүйгээр хүнсний асуудлыг шийдэх;
  - Уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээ авахдаа газар ашиглалтын өөрчлөлтийг нэмэгдүүлэхгүй байх, биологийн олон янз байдлыг хамгаалах;
  - Байгалийг хамгаалах, нөхөн сэргээхийн зэрэгцээ хүмүүсийн амьдралд эерэг нөлөөлөл үзүүлэх;
  - Байгаль болон хүний төлөө цэнгэг усыг хамгаалах;
  - Тэлж хөгжиж байгаа хот, суурин газрын хэрэгцээг хангахдаа экосистем, биологийн олон янз байдлыг хамгаалах;

Зураг 5. Дэлхийн биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээний үнэлгээний загвар, 2019




Зураг 6. Дэлхийн тогтвортой байдлыг бий болгох хөшүүрэг (Transformative change)



Эх сурвалж: The IPBES Global Assessment on Biodiversity and Ecosystem Services, IPBES, May 2019


Зураг 7. Экосистемийн үйлчилгээний нэр томъёоны өөрчлөлт




Эх сурвалж: The IPBES Global Assessment on Biodiversity and Ecosystem Services, IPBES, May 2019

Зураг 8. Зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх багц процесс


1. Биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээний үнэлгээ



2. Ногоон хөгжлийн бодлогод нийцтэй хөгжлийн төлөвлөлт



3. Орон нутгийн удирдлага, хүмүүсийн оролцоог хангах, чадавхийг бэхжүүлэх



Процессийн загвар гаргасан: Р.Оюун, О.Номин-Эрдэнэ, 2020

Хүснэгт 4. Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэл

| Хүнс  | Уур амьсгал  | Байгаль хамгаалал  | Ус хамгаалал  | Хот, суурин  |
|---|--|--|---|--|
| <ul style="list-style-type: none"> <li>• ХАА-н үйлдвэрлэл</li> <li>• Хүнсний хэрэглээ, эрүүл хооллолт</li> <li>• Ханган нийлүүлэлтийн сүлжээ</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• ГЗБЕТ, газарт суурилсан шийдэл</li> <li>• Эрчим хүчний хэмнэлт</li> <li>• Байгаль, экосистемд суурилсан шийдэл</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• ТХГ</li> <li>• Мониторинг, хяналтын систем</li> <li>• Хамгаалал, нөхөн сэргээлт</li> <li>• Уламжлалт мэдлэг туршлага</li> <li>• Хамтын хариуцлага</li> <li>• Ногоон ажлын байр</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• УННМ</li> <li>• Усны сав газар, ус хамгаалал</li> <li>• Цэвэр ус ба хүнс</li> <li>• Цэвэр ус ба эрчим хүч, уур амьсгал</li> <li>• Ус ханган нийлүүлэлтийн сүлжээ</li> <li>• Усны хэрэглээ</li> <li>• Үерийн эрсдэлийн менежмент</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Хотын тогтвортой хөгжил</li> <li>• Газар ашиглалт, ногоон бүс</li> <li>• Эдийн засгийн урсгал ба зайнаас хамтрах (telecoupling)</li> <li>• Үйлдвэрлэл, хэрэглээ, тээвэрлэлт, хаягдлын сүлжээ</li> </ul> |

Эх сурвалж: The IPBES Global Assessment on Biodiversity and Ecosystem Services, IPBES, May 2019

### 3. БАЙГАЛЬД ЗОХИСТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ

#### 3.1. Хууль эрхзүйн орчин

##### 3.1.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг

ХБТУТ хуульд зааснаар Монгол улс хөгжлийн урт (30 жил), дунд (5, 10 жил), богино (1, 4 жил) хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй. 30 жилийн баримт бичиг нь улсын хөгжлийн Алсын хараа – 2050, 10 жилийн баримт бичиг нь Хөгжлийн зорилтот хөтөлбөр, 5 жилийн баримт бичиг нь улс, аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх үндсэн чиглэл, 4 жилийн баримт бичиг нь засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 1 жилийн баримт бичиг нь тухайн жилийн төлөвлөгөө юм. Баянхонгор аймаг нь хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэлтэй байна.

Хуулийн 4.1.7-д зааснаар “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (цаашид УХ5ҮЧ гэх), Хөгжлийн зорилтот хөтөлбөрт (цаашид ХЗХ гэх) суурилсан орон нутгийн онцлогийг тусгасан дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг юм.

#### Хүснэгт 5. Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг

| Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хугацаа | Төлөвлөлтийн баримт бичиг                                  | Улс | Бүс | Аймаг     | Сум  |
|--|--|-----|-----|-----------|------|
| Урт хугацааны (30 жил):                | Алсын хараа  |     |     |           |      |
| Дунд хугацааны (10 жил):               | Хөгжлийн зорилтот хөтөлбөр                                 |     |     | 2012-2030 |      |
| Дунд хугацааны (5 жил):                | Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл |     |     | 2025      | 2030 |
| Богино хугацааны (4 жил):              | Үйл ажиллагааны хөтөлбөр                                   |     |     |           |      |
| Богино хугацааны (1 жил):              | Жилийн төлөвлөгөө  |     |     |           |      |

Баянхонгор аймаг АХ5ҮЧ, тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөг 2020.12.04-ний өдөр тус тус баталсан байна. Уг төлөвлөгөөний агуулга нь Алсын хараа-2050, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Ногоон хөгжлийн бодлого 2030-тай хэрхэн нийцэг байгааг 5-р бүлэгт оруулав.

#### 3.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо


Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (ХБТУТ хууль, 2020)-д хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо, оролцогч талууд, тэдний үүрэг, хариуцлагыг тодорхой заасан (Зураг 9) байдаг ч баг, хороодын Иргэдийн нийтийн хурал, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудын оролцооны талаар тодорхой заалт байхгүй байна.

Зураг 9. Хөгжлийн бодлого, төлөвлөлтөнд оролцогч талууд



Хуульд зааснаар Хөгжлийн зорилтот хөтөлбөрт (цаашид ХЗХ гэх)-ийг Үндэсний хөгжлийн газар, аймгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг Засаг дарга Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газартай хамтран боловсруулж, Үндэсний хөгжлийн газар санал өгч, аймгийн ИТХ батлана. Салбарын бодлого ХЗХ-өөр дамжин аймгийн үндсэн чиглэлд тусгагддаг.

Зураг 10. Хөгжлийн зорилтот хөтөлбөр ба аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулах тогтолцоо



- **ЗГ:** журам, үлгэрчилсэн загвар
- **УХГ:** нэгдсэн аргазүй
- **УХХ:** Аргазүйн дэмжлэг
- **ҮСХ:** шалгуур үзүүлэлт, мэдээллийн эх үүсвэр, тооцох аргачлал, зөвлөмж
- **Яамд:** Салбарт баримталдаг журам, аргачлал, үзүүлэлт

---

### 3.3. АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ БОЛОВСРУУЛАХ

---

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2020 оны ХЭГ/2361 дугаар албан бичгийн хавсралтанд зааснаар Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийн бүтэц нь Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-8 дугаар хэсгийн зорилго, зорилттой нийцтэй байна. Үүнд Ногоон хөгжлийн зорилго нь дараах 4 зүйлийг агуулсан байна:

1. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах,
2. Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх,
3. Байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлэх
4. Хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах

Ногоон хөгжил болон Үндсэн чиглэлийн бусад зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилтоос Баянхонгор аймгийн байгальд зохистой хөгжилтэй холбогдох арга хэмжээг түүвэрлэн доор жагсаав:

1. Эх байгаль анхдагч экосистем
  - Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50 хувийг улсын ТХ-д авна.
  - Түүх соёлын дурсгалт газар, ус, ой, экосистем, ховор ан амьтан, ургамлын тархац бүхий нутаг, өвөрмөц тогтоцтой экосистемийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авч тухайн бүс нутагт ажиллаж, амьдарч буй иргэд, бүлэг, нөхөрлөлтэй хамтран хамгаалалтын оновчтой бодлогыг хэрэгжүүлэх
2. Байгалийн баялгийн үр өгөөж
  - Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээнэ
  - Ховор, нэн ховор амьтан ургамлыг сэргээн нутагшуулах, тарималжуулах, генийн санг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх аймгийн бодлогыг тодорхойлж, гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт хамруулах;
  - Гол, горхи, булаг, шандны эх, гүний худгуудын хамгаалалтын бүсэд болон цөлжилт, элсний нүүдэлд автаж хөрсний элэгдэлд орсон газруудад гүнээс чийг татаж амьдрах чадвартай заг, тоорой, сухай, хайлаас зэрэг мод болон харгана, торлог, тэсэг, шавга, шар мод зэрэг бутлаг ургамлуудыг тарьж ногоон хэрмийг бий болгох, Түй, Байдраг, Шаргалжуут, Цагаан туруут зэрэг томоохон голуудын ай савын дагуу мод тарьж ойн сангийн хэмжээг нэмэгдүүлэх
  - Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлнэ
  - Байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана.
3. Үнэт баялаг ус
  - Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах
  - Усны бохирдол, хомсдолыг бууруулна.
  - Хөв цөөрөм, далд усан сан байгуулна
  - Нийт хүн амын 85-аас доошгүй хувийг шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангана.
  - Нийт газар нутгийн 23 хувьд гидрогеологийн дунд масштабын зураглал хийнэ

- Усны нөөц баялгийн мэдээллийн бааз суурийг өргөжүүлж, төлөвлөлт, менежмент хийх боломж бүрдүүлнэ.
4. Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил
    - Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулна.
    - Ус, цаг уурын ажиглалт, орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлнэ
    - Цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.
    - Хүлэмжийн хийн ялгарлыг 10 хувиар бууруулна.
    - Хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээ 20 хувьд хүргэнэ.
    - Аймгийн төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдэж, хог дахин боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.
  5. Аялал жуулчлал
    - Түүх соёлын дурсгал болон байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэсэн аялал жуулчлалыг соёлын цогц үйлчилгээтэй хослуулан хөгжүүлж, соёл урлагийн брэнд бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах.
    - Архангай аймагт ирсэн аялагчдыг Хөл сая, Эгийн даваагаар дамжуулж аймгийнхаа хангайн чиглэлийн маршруттай холбох, Өвөрхангай аймагт ирсэн жуулчдыг Найман нуураас Элбэхийн даваагаар дамжуулж Шаргалжуутын маршруттай холбох, Өмнөговь аймагт ирсэн аялагчдыг Баянлигийн говийн маршруттай холбох стратегийг хэрэгжүүлснээр жуулчдын тоог нэмэгдүүлэх, Шаргалжуутад аялал жуулчлалын цогцолбор байгуулах
    - Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
    - Дотоодын аялалыг хөгжүүлэх зорилгоор Өргөөтийн рашаан, Өхөгийн амралт, Жаргалант сумын Биндэръяа Хөх нуур, Гурванбулагийн Хөх нуур, Бөөн цагаан нуур, Орог нуур, Эрхэт, Тамчийн хавцал, Өвгөнжаргалант болон байгалийн үзэсгэлэнт газруудыг тохижуулж, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал (НИТАЖ)-ыг хөгжүүлснээр нүүдлийн ахуй соёлоо хадгалан үлдэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, зохион байгуулалттай эвент арга хэмжээнүүдийг бий болгох, жуулчдын урсгалыг татах нөхцөлийг бүрдүүлэх.
  6. Хөдөө аж ахуй
    - Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангана.
  7. Газрын харилцаа
    - Орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
  8. Бүс, орон нутгийн хөгжил
    - Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ
    - Орон нутгийн мэдээлэл болон цаг агаарын урьтаж анхааруулах мэдээг малчдад дамжуулж бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборыг аймгууд, аюулын эрсдэл өндөртэй зарим сумдад үе шаттайгаар байгуулна.
    - Аймаг, сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж, сумдад “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

## 4. ТӨСЛИЙН ТАЛБАЙН СУУРЬ СУДАЛГАА, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ, НУТГИЙН ХҮН АМЫН ХЭРЭГЦЭЭТ БАЙДЛЫН СУДАЛГАА

### 4.1. Нийгмийн үзүүлэлт

Баянхонгор аймгийн нийгмийн үзүүлэлтэнд хүн ам, шилжилт хөдөлгөөн, дундаж наслалт өвчлөл, ажилгүйдлийн түвшин, ХХИ, ДНБ талаар тусгав. Нийгэм эдийн засгийн ерөнхий үзүүлэлтийн дараах хүснэгтэнд оруулав.


#### Хүснэгт 6. Нийгэм эдийн засгийн ерөнхий үзүүлэлт

| Үзүүлэлт                                 | Хэмжих нэгж | Он   | Баянхонгор | Хангайн бүс |
|--|-------------|------|------------|-------------|
| Суурин хүн амын тоо                      | хүн         | 2019 | 88,672     | 605,216     |
| Шилжин ирсэн хүний тоо                   | хүн         |      | 483        | 5438        |
| Шилжин явсан хүний тоо                   | хүн         |      | 844        | 8320        |
| Цэвэр шилжих хөдөлгөөн                   | хүн         |      | - 361      | - 2882      |
| 1 хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн | мян.төг     |      | 5,410.70   | 8,038.60    |
| Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн       | сая.төг     |      | 476,761.7  | 4,805,749.6 |
| Ажиллах хүч                              | тоо         |      | 35,999     | 260,745     |
| Хөдөлмөр эрхлэлтийн түвшин               | тоо         |      | 55.3       | 61.8        |
| Ажилгүйдлийн түвшин                      | тоо         | 2018 | 7.30%      | 7.10%       |

#### 4.1.1. ХҮН АМ

Баянхонгор аймгийн нийт хүн ам 2019 оны жилийн эцсийн байдлаар 88,672 байна. 2040 онд нийт хүн амын тоо 111118 хүрэх буюу 20%-иар, жилд дунджаар 1.13%-иар өсөх төлөвтэй байна.

#### Зураг 11. Хүн амын өсөлтийн ирээдүйн төлөв



Баянхонгор аймгаас 2019 онд шилжин явсан хүний тоо 30%-иар өсч 844, шилжин ирсэн хүний тоо 15.5%-иар буурч 483 болсон байна. Сүүлийн дөрвөн жилийн дунджаар шилжин явсан хүний тоо 886, шилжин ирсэн хүний тоо 694 байна.



Хүн амын дундаж наслалт 2019 оны байдлаар 70.37 буюу улсын дунджаас 0.04-р бага байна. Үүнээс эрэгтэйчүүдийн дундаж наслалт 67.35, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 72.23 байна.

Зураг 12. Шилжилт хөдөлгөөн, хүн амын дундаж наслалт



#### 4.1.2. Ажил эрхлэлт болон ажилгүйдлийн түвшин

Баянхонгор аймгийн ажилгүйдлийн түвшин 7.3% байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 1.7% өссөн байна. Тус аймгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 55.3% байгаа нь бүсийн дүнгээс доогуур, улсын дүнтэй харьцуулахад 0.9% илүү байна.

Зураг 13. Ажил эрхлэлт болон ажилгүйдлийн түвшингийн ирээдүйн төлөв




## 4.2. Эдийн засгийн үзүүлэлт

Эдийн засгийн үзүүлэлтэнд мал аж ахуй, газар тариалангийн салбарыг авч үзэв.

### 4.2.1. Мал, аж ахуй

Баянхонгор аймгийн нийт бэлчээрийн малын тоо 2010-2017 онд жилд дунджаар 11%-иар өссөн бол 2018 онд өмнөх онтой харьцуулахад 8%-иар буурсан, 2019 онд 9%-иар өссөн үзүүлэлттэй байна. Дараагийн 10 жилд ган, зуд зэрэг байгалийн хүчин зүйл болохгүй гэж үзвэл малын тоо толгой өсөх төлөвтэй байна.


## Зураг 14. Бэлчээрийн малын өсөлтийн ирээдүйн төлөв, төрлөөр



### 4.2.2. ГАЗАР ТАРИАЛАН

Баянхонгор аймгийн хэмжээгээр газар тариалангаас 30 тэрбум хүртэлх төгрөгний орлого олох боломжтой байна. Мөн эрчимжсэн газар тариаланг хөгжүүлэх, тариалалтын талбайг нэмэх зэргээр орлогоо өсгөх боломжтой.

## Зураг 15. Газар тариалангийн хураан авалт, олох орлого, ирээдүйн төлөв



### 4.3. Хөгжлийн өнөөгийн байдал

**Хүний хөгжил:** Баянхонгор аймгийн нийгэм-эдийн засгийн статистик мэдээллийг цуглуулж хүний хөгжлийн индексийг 2015-2019 оны байдлаар харьцуулж, цаашдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон.

#### Хүснэгт 7. Аймгуудын хүний хөгжлийн индекс

| № | Аймгийн нэр | 2015  | 2016  | 2017  | 2018  | 2019  | Тайлбар   |
|---|-------------|-------|-------|-------|-------|-------|---|
| 1 | Баянхонгор  | 0.657 | 0.651 | 0.649 | 0.651 | 0.659 | Орлого өсөөгүй, боловсролын индекс буурсан нөлөөлсөн. |

Судалгаанаас харахад Баянхонгор аймгийн Хүний Хөгжлийн Индекс (ХХИ) 2019 онд өмнө оноос 1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2018 он хүртэл хүн амын дундаж наслалт улсын дунджаас доогуур, шилжилт хөдөлгөөний улмаас боловсролын индекс жил бүр буурсан, ажлын байрны дутагдалтай, ажилгүйдэл ихтэй, хүн амын орлого 2015 оны төвшнөөс буурсан. Харилцаа холбооны хөгжил сул, интернет нутаг дэвсгэрийн 10 орчим хувьд хүрч байгаа хэдий ч үзүүлэлт нь муу, тариф өндөр, багуудын нутаг дэвсгэр хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд бүрэн хамрагдаагүй байна.

**Хэрэгцээ:** Хүний хөгжлийг тэгш, жигд байлгах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, ажлын байр, хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах ингэснээр хүн амын амьдралын түвшин, чанарыг дээшлүүлж тогтвортой хөгжлийн нийгмийн зорилтуудыг биелүүлэх, улмаар хүн амын наслалтыг улсын дунджид хүргэх хэрэгтэй байна.


**Амьдрах орчин:** Баянхонгор аймаг болон Баянцагаан, Баацагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумын төвийн суурин газарт ногоон байгууламж хангалтгүй. Хог хаягдал сум, аймгийн төв, гол ус, аялал жуулчлалын хэсэгт үүсч хуримтлагдсан байна. Энэ нь байгаль орчин, нийгэм, хүн, амьтны эрүүл мэнд, аялал жуулчлалын бизнесийн үйл явцад сөрөг нөлөө үзүүлж байна. Уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн даац хэтрэлт, хөрс ургамлын талхагдал, доройтол, зэрлэг амьтны амьдрах орчин, хамгаалах үйл ажиллагаа хангалтгүй зэргээс экосистемийн тэнцвэр алдагдах эрсдэлтэй болж байна.

**Хэрэгцээ:** Хог хаягдлын менежментийг сайжруулах, иргэдийн байгаль орчноо хамгаалах, ардын уламжлалт зан заншлыг сэргээх, боловсрол олгох, дадал эзэмшүүлэх хэрэгцээ шаардлага байна. Бэлчээр, зэрлэг амьтныг хамгаалах, хот суурин газарт хог хаягдлын менежментийг сайжруулах, орчны бохирдлыг бууруулах, дулааны асдуулыг шийдэх, зам тээвэр, холбооны дэд бүтцийг сайжруулах, Интернетийн үнийг буулгах, хурдыг нэмэгдүүлэх зэрэг хэрэгцээ байна гэж үзэж байна.

**Эдийн засаг:** Үйлдвэрлэл, үйлчилгээ хангалтгүй, ЖДҮ, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдалтай, ажлын байр дутмаг, үүнтэй уялдаад хүн амын хөдөлмөр эрхлэлт, цалин орлого бага байна.

**Хэрэгцээ:** Сумдад үйлдвэрлэл бий болгох, ялангуяа арьс, шир, ноос, ноолуур, мах, сүү, жимс боловсруулах чиглэлээр. Мөн мах, сүүний хөргөгч, хөлдөөгч сумдад дутагдалтай байна.

Зураг 16. Хүний хөгжлийн индекс, ирээдүйн төлөв




Завхан аймгийн Хүний Хөгжлийн Индекс : content

2010-2020 он хүртэл жилд дунджаар 3%-ийн өсөлттэй, 2022 оноос хойш жилд дунджаар 1%-иар өсөх төлөвтэй байна.

#### 4.4. Дотоодын нийт бүтээгдэхүүн

2003-2019 оны хоорондох нэгж талбайд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний статистик мэдээг ENSURE төсөлд хамрагдах 4 аймгаар харьцуулж, голлох салбаруудын ДНБ-ний өсөлт, бууралтын шалтгаанд дүн шинжлэл хийсэн.

Зураг 17. Аймгуудын ДНБ, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ



2019 оны байдлаар аймгуудын ДНБ-ийг харьцуулвал Архангай аймаг хамгийн их ДНБ-тэй бөгөөд үүнээс хөдөө аж ахуй 59.1%, аж үйлдвэр 18.9%, үйлчилгээний салбар 22%-ийг бүрдүүлж байна. Хоёрдугаарт Баянхонгор аймаг хөдөө аж ахуй 43.1%, аж үйлдвэр 26%, үйлчилгээний салбар 30.8%-ийг бүрдүүлж байна.

2003-2013 оны хооронд Говь-Алтай аймгийн хүн амын тоо жилд дунджаар 632-аар, Завхан аймаг 1415.3-аар, Архангай аймаг 790-аар, Баянхонгор аймаг 152-аар тус тус буурсан бол Улаанбаатар хотын хүн ам 44,494-аар нэмэгдсэн байна. Эндээс үзэхэд тус аймгийн иргэд Улаанбаатар хот руу шилжин суурьшсан байна.

Харин 2013-2014 оны хооронд хооронд төсөл хэрэгжих 4 аймгийн хүн амын тоо огцом өссөн бөгөөд шалтгаан нь тодорхойгүй, 2014-2015 оны хооронд эдгээр аймгийн хүн амын тоо буурсан ба бууралтын шалтгаан нь мөн л хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу шилжин суурьшсантай холбоотой.

Зураг 18. Аймгуудын дотоодын нийт бүтээгдэхүүн (2003-2019)




Төсөл хэрэгжих аймгуудын ДНБ нь 2003-2019 оны хооронд алгуур өсөлттэй байсан хэдий ч 2009-2010 онд буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь 2008 онд дэлхийн дахинд эдийн засгийн хямрал нүүрлэсэн, мөн 2009-2010 оны өвөл Монгол орон даяар болсон томоохон зудын улмаас 15 аймгийн 80 сум гамшгийн, 18 аймгийн 95 сум зудын байдалд орж, нийт 10.2 сая мал хорогдсон нь ДНБ-ний бууралтын гол хүчин зүйл болсон байна.

Мөн 2016 онд Говь-Алтай аймгаас бусад аймгуудын ДНБ буурсан үзүүлэлттэй байна. Хэдийгээр 2010 онтой харьцуулахад харьцангуй бага хохирол учруулсан боловч 2016 оны ДНБ-ний бууралт нь 2010 онтой харьцуулахад хэд дахин их байна. Үүний гол шалтгаан нь 2016 оны УИХ-ын сонгууль болон Монгол улсын экспортын томоохон хувийг бүрдүүлдэг зэсийн үнэ олон улсын зах зээл дээр 50 орчим хувиар буурснаас төгрөгийн ханш 20 орчим хувиар буурсантай холбоотой байж болзошгүй.


2008 онд Говь-Алтай аймгийг 2008-2021 он хүртэл хөгжүүлэх цогц бодлого хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэхүү бодлогын үндсэн зорилгуудын нэг нь үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлэх байсан бөгөөд жил бүр Говь-Алтай аймгийн эдийн засаг нь хөдөө аж ахуйн салбараас хамаарах хамаарал буурсан. Үүний үр дүнд 2016 оны зуд Говь-Алтай аймгийн ДНБ-д маш бага нөлөөлөл үзүүлсэн байна.

Зураг 19. Аймгуудын нэгж талбайд ноогдох ДНБ (2003-2019)



2003-2019 оны хооронд аймгуудын нэгж талбайд ноогдох ДНБ-ний хэмжээгээр Архангай аймаг хамгийн их байсан бөгөөд Говь-Алтай аймаг хамгийн бага байна. Харин газар нутгийн хувьд Говь-Алтай аймаг том, Архангай аймаг бага хэмжээтэй байна. Эндээс үзэхэд мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломж нь тухайн газар нутгийн байгаль цаг уурын нөхцөл, байгалийн бүс, бүслүүрийн онцлог, дэд бүтэц, газар ашиглалтын тохиромжтой байдал зэргээс хамаарч байна.

Зураг 20. Аймгуудын нэг хүнд ноогдох ДНБ (2003-2019)



Нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээгээр 4 аймаг нь ижил түвшинд байна. Нэг хүнд ноогдох ДНБ нь нийт ДНБ-тэй шууд хамааралтай бөгөөд хүн амын тоотой урвуу хамааралтай байдаг. Хэдийгээр өмнө дурдаж байснаар 2014-2019 онуудын хооронд аймгуудын хүн амын тоо өсөлттэй байсан ч нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй байна.

## 5. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ

### 5.1. Хөгжлийн ба байгаль хамгаалах төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн өнөөгийн байдлын үнэлгээ

ENSURE төсөл хэрэгжих 4 талбараас Зарман говь, Улаан шалын талбар нь Баянхонгор аймгийн Баацагаан, Баян-Өндөр, Баянцагаан, Шинэжинст сумын нутаг дэвсгэрт хэрэгжинэ.

Баянхонгор аймгийн хөгжлийн бодлого, тогтвортой хөгжлийн зорилт, ногоон хөгжлийн хөтөлбөр, ЗДҮАХ, ГЗБЕТ зэрэг дунд, урт хугацаанд баримтлан хэрэгжүүлэх бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд байна (Хүснэгт 8).

#### Хүснэгт 8. Аймгуудын хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хугацаа

| № | Баримт бичиг                          | Баянхонгор                            |
|---|---------------------------------------|---------------------------------------|
| 1 | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр | 2016-2020                             |
| 2 | Ногоон хөгжлийн хөтөлбөр              | 2018-2028                             |
| 3 | Хөгжлийн бодлого                      | 2016-2025, 2026-2030                  |
| 4 | ГЗБЕТ                                 | 2005 - 2010, 2010 - 2015, 2015 - 2020 |

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэр нь Алтайн-Өвөр говь, Орог нуур-Түйн гол, Бөөн цагаан нуур-Байдраг, Хяргас нуур – Завхан голын усны сав газруудад харьяалагддаг, сав газар бүр УННМТ-тэй (Хүснэгт 9). Энэ нь аймаг, сумын хөгжилд усны нөөц, хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний ус хангамжийн асуудлыг шийдэх удирдлага, үйл ажиллагаа, бүтээн байгуулалтанд баримтлах гол баримт бичиг юм.

#### Хүснэгт 9. Баянхонгор аймгийн нутаг дэвсгэр хамрагдах сав газар, зарим УННМТ-ний хугацаа

| № | Сав газар                   | Хугацаа                         |
|---|-----------------------------|---------------------------------|
| 1 | Алтайн-Өвөр говь            | 2019-2020, 2021-2025, 2026-2030 |
| 2 | Орог нуур Түйн гол          | 2018-2021, 2022-2025, 2026-2030 |
| 3 | Бөөнцагаан нуур Байдраг гол | 2014-2017, 2018-2021            |
| 4 | Хяргас нуур-Завхан гол      | 2015-2017, 2018-2021            |

#### 5.1.1. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Баянхонгор аймгийн ЗДҮАХ нь Хүний хөгжил, нийгмийн бодлого, Эдийн засгийн өсөлт, үйлдвэржилт, Хүнс, ХАА, байгаль орчин, ногоон хөгжил, Дэд бүтэц, Засаглал, гадаад харилцаа, нийгмийн аюулгүй байдлыг хангах гэсэн 5 бүлэг, нийт 153 арга хэмжээ дэвшүүлсэн. Үүнээс Хүний хөгжил, нийгмийн асуудалд түлхүү анхаарч 66 (43%), Хүнс, ХАА, байгаль орчинд 28 (18%), эдийн засаг 24 (16%), дэд бүтэц 21 (14%), засаглал 14 (9%) арга хэмжээ дэвшүүлсэн байна.

Аймгийн хөгжлийн хэтийн зорилтын үр дүнг 19 үзүүлэлтээр илэрхийлэхээр заасан. Үүнд 2014 оныг суурь болгоод 2020, 2030 онд ямар болохыг хувь болон аймгуудын дунд эзлэх байраар тодорхой заасан байна.

ЗДҮАХ-т байгаль орчин, ногоон хөгжилтэй холбоотой 61 зорилт (нийт 153 зорилтын 30%) байна. Эдгээрээс хамгийн олон 17 зорилт бэлчээрийн мал аж ахуйн эрсдэлийг бууруулах, байгаль хамгаалал, экосистемийн тэнцвэрийг хангах 13 зорилт байна.

Бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх, тэжээл тариалах, эрсдэлээс сэргийлэх, хөрсний эвдрэлийг багасгах, газар тариалан хөгжүүлэх талаар 22, байгаль хамгаалал, экологийн чиглэлээр 18 зорилт дэвшүүлсэн нь хамгийн олон байна. Иргэдэд экологийн боловсрол олгох, цөлжилтөөс хамгаалах, хэсэгчилсэн ойн зурвасыг байгуулах, төв, суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх “Ногоон Баянхонгор” хөтөлбөр болон агаар, хөрсний бохирдлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлэх, сум бүрт хог боловсруулах жижиг үйлдвэр байгуулж хоёрдогч түүхий эдийг ашиглах, байгаль экологид ээлтэй цаасан уут, сав баглаа боодлын болон даавуун уутны жижиг үйлдвэрлэл бий болгож гялгар, нийлэг уутны хэрэглээг халах зэрэг зорилт дэвшүүлсэн байна.

Усны талаар нөөцийг нэмэгдүүлэхийн тулд гүн өрмийн болон гар худаг гаргах, хөв цөөрөм байгуулах, аймгийн цэвэрлэх байгууламжид хэт ягаан туяаны цэвэршүүлэгч суурилуулах зорилт дэвшүүлсэн байна.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар 7 зорилт дэвшүүлсэн. Эмчилгээний өндөр ач холбогдол бүхий рашаан сувилал, амралт, байгалийн үзэсгэлэнт, түүх дурсгалт газруудыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, амралт аялал жуулчлалын 3 бүс цогцолборыг иж бүрэн тохижуулах, сум бүр аялалын маршрут, брэнд бүтээгдэхүүн үйлчилгээтэй болж аймгийн аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд холбогдох, “Хот айл-жуулчны бааз” төсөл хэрэгжүүлж малчин өрхүүд жуулчин хүлээн авч, өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломж, Баянхонгор сумын багууд, сум бүрт амралт, чөлөөт цагийн шинэ орчин бүрдүүлэх зэрэг зорилт дэвшүүлжээ.

#### **5.1.2. Баянхонгор аймгийн 2017-2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн жилийн эцсийн хэрэгжилт**

Баянхонгор аймгийн 2017-2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөлтийн биелэлтийг дараах хүснэгтэнд жил жилээр тусгав.

2017 онд 89 арга хэмжээ хэрэгжүүлснээс үр дүнтэй буюу 100% үнэлгээтэй 32, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70% үнэлгээтэй 23, эрчимжүүлэх шаардлагатай буюу 40% үнэлгээтэй 15, үр дүнгүй буюу 0% үнэлгээтэй 9 арга хэмжээ нийт 59.1% гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн (Хүснэгт 10).



Хүснэгт 10. ЗДҮАХ, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, 2017 он

| Үзүүлэлт                                      | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн явцын үнэлгээ |                                  |                                   |                   | Хугацаа болоогүй | Хэрэгжилтийн хувь |
|---|--------------------|----------------------------|----------------------------------|-----------------------------------|-------------------|------------------|-------------------|
|   |                    | Үр дүнтэй буюу 100%        | Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70% | Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40% | Үр дүнгүй буюу 0% |                  |                   |
| 1 Хүний хөгжил, нийгмийн бодлого              | 10                 | 5                          | 2                                | 2                                 | 1                 |                  | 72.0              |
| 2 Хүнс хөдөө аж ахуй, байгаль орчин НХБ       | 37                 | 16                         | 13                               | 5                                 | 1                 |                  | 73.2              |
| 3 Эдийн засгийн өсөлт, үйлдвэржилтийн бодлого | 15                 | 3                          | 2                                | 4                                 | 5                 |                  | 40.0              |
| 4 Засаглалын бодлого                          | 27                 | 8                          | 6                                | 4                                 | 2                 |                  | 51.1              |
| <b>Нийт</b>                                   | <b>89</b>          | <b>32</b>                  | <b>23</b>                        | <b>15</b>                         | <b>9</b>          | <b>0</b>         | <b>59.1</b>       |

2018 онд 148 арга хэмжээ хэрэгжүүлснээс үр дүнтэй буюу 100% үнэлгээтэй 122, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70% үнэлгээтэй 16, эрчимжүүлэх шаардлагатай буюу 40% үнэлгээтэй 5, үр дүнгүй буюу 0% үнэлгээтэй 3 арга хэмжээ нийт 94.9% гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн (Хүснэгт 11).

Хүснэгт 11. ЗДҮАХ, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, 2018 он

| Үзүүлэлт                                  | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн явцын үнэлгээ |                                  |                                   |                   | Хугацаа болоогүй | Хэрэгжилтийн хувь |
|---|--------------------|----------------------------|----------------------------------|-----------------------------------|-------------------|------------------|-------------------|
|   |                    | Үр дүнтэй буюу 100%        | Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70% | Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40% | Үр дүнгүй буюу 0% |                  |                   |
| 1 Хүний хөгжил, Нийгмийн хөгжлийн бодлого | 14                 | 14                         | 0                                | 0                                 | 0                 | 0                | 100               |
| 2 Үйлдвэржилт байгаль орчин НХ бодлого    | 71                 | 56                         | 9                                | 3                                 | 1                 |                  | 89.4              |
| 3 Нийгмийн хөгжлийн бодлого               | 10                 | 10                         | 0                                | 0                                 | 0                 | 0                | 100               |
| 4 Засаглалын бодлого                      | 53                 | 42                         | 7                                | 2                                 | 2                 |                  | 90.0              |
| <b>Нийт</b>                               | <b>148</b>         | <b>122</b>                 | <b>16</b>                        | <b>5</b>                          | <b>3</b>          | <b>0</b>         | <b>94.9</b>       |

2019 онд 63 арга хэмжээ хэрэгжүүлснээс үр дүнтэй буюу 100% үнэлгээтэй 53, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70% үнэлгээтэй 8, эрчимжүүлэх шаардлагатай буюу 40% үнэлгээтэй 2 арга хэмжээ нийт 93.5% гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн (Хүснэгт 12).

Хүснэгт 12. ЗДҮАХ, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, 2019 он

| Үзүүлэлт                                 | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн явцын үнэлгээ |                                  |                                   |                   | Хугацаа болоогүй | Хэрэгжилтийн хувь |
|--|--------------------|----------------------------|----------------------------------|-----------------------------------|-------------------|------------------|-------------------|
|  |                    | Үр дүнтэй буюу 100%        | Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70% | Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40% | Үр дүнгүй буюу 0% |                  |                   |
| 1 Хүний хөгжил нийгмийн бодлого          | 11                 | 9                          | 2                                | 0                                 |                   | 0                | 94.5              |
| 2 Хөдөө аж ахуй байгаль орчин НХ бодлого | 20                 | 17                         | 3                                |                                   |                   |                  | 95.5              |
| 3 Нийгмийн хөгжлийн бодлого              | 3                  | 2                          | 1                                |                                   |                   |                  | 90                |
| 4 Засаглалын бодлого                     | 29                 | 25                         | 2                                | 2                                 |                   |                  | 93.8              |
| <b>Нийт</b>                              | <b>63</b>          | <b>53</b>                  | <b>8</b>                         | <b>2</b>                          | <b>0</b>          | <b>0</b>         | <b>93.5</b>       |

2020 онд 77 арга хэмжээ хэрэгжүүлснээс үр дүнтэй буюу 100% үнэлгээтэй 47, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70% үнэлгээтэй 17, эрчимжүүлэх шаардлагатай буюу 40% үнэлгээтэй 3 арга хэмжээ, үр дүнгүй буюу 0% үнэлгээтэй 10 арга хэмжээ нийт 80.8% гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн (Хүснэгт 13).

Хүснэгт 13. ЗДҮАХ, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, 2020 он

| Үзүүлэлт                                 | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн явцын үнэлгээ |                                  |                                   |                   | Хугацаа болоогүй | Хэрэгжилтийн хувь |
|--|--------------------|----------------------------|----------------------------------|-----------------------------------|-------------------|------------------|-------------------|
|  |                    | Үр дүнтэй буюу 100%        | Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70% | Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40% | Үр дүнгүй буюу 0% |                  |                   |
| 1 Хүний хөгжил нийгмийн бодлого          | 12                 | 10                         | 1                                | 0                                 | 1                 | 0                | 89.2              |
| 2 Хөдөө аж ахуй байгаль орчин НХ бодлого | 27                 | 15                         | 3                                | 2                                 | 7                 | 0                | 66.3              |
| 3 Нийгмийн хөгжлийн бодлого              | 11                 | 6                          | 5                                | 0                                 | 0                 | 0                | 86.4              |
| 4 Засаглалын бодлого                     | 27                 | 16                         | 8                                | 1                                 | 2                 |                  | 81.5              |
| <b>Нийт</b>                              | <b>77</b>          | <b>47</b>                  | <b>17</b>                        | <b>3</b>                          | <b>10</b>         | <b>0</b>         | <b>80.8</b>       |

Эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй зорилт, арга хэмжээнүүдийн ихэнх нь улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн байна. Хэрэгжилт удаашралтай, үр дүнгүй байгаа шалтгаан нь хөрөнгө санхүүгийн эх үүсвэр хүрэлцээгүй, тооцоо судалгаа дутуу хийж арга хэмжээг төлөвлөсөнтэй холбоотой.

### 5.1.3. Төсөлд ХАМРАГДАХ СУМДЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР

ЗДҮАХ-ийн нийгэм, эдийн засаг, засаглалын бодлогын хүрээнд ENSURE төсөл хэрэгжих 4 суманд тусгайлан заасан зорилт байхгүй, гэхдээ уг хөтөлбөр хэрэгжсэн тохиолдолд сумдад дараах дэвшил гарахаар байна:

- Сум бүр аялалын маршрут, брэнд бүтээгдэхүүн үйлчилгээтэй болж аймгийн аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд холбогдсон байх
- Сум бүрт “Хот айл-жуулчны бааз” төсөл хэрэгжиж малчин өрхүүд жуулчин хүлээн авч, өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжтой болсон байх
- Сум бүрт хог боловсруулах жижиг үйлдвэр байгуулагдаж хоёрдогч түүхий эдийг ашигладаг болсон байх
- Сум бүрт байгаль экологид ээлтэй цаасан уут, сав баглаа боодол, даавуун уутны жижиг үйлдвэрлэл бий болсон байх
- Бөөнцагаан нуурын орчимд жуулчны бааз байгуулагдсан байх

### 5.1.4. НОГООН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР (НХХ)

Баянхонгор аймаг 2018-2028 онд хэрэгжүүлэх Ногоон хөгжлийн хөтөлбөртэй. Энэ нь 7 стратегийн зорилт, 227 зорилтот арга хэмжээтэй, Ногоон хөгжлийн бодлогын үзэл баримтлал, зарчмыг тусгасан байна.

Хөрөнгө оруулалтын нийт дүн 1 их наяд, 380 тэрбум 845 сая төгрөг. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг НХБ-ын үзэл баримтлал, зарчимд нийцтэй байгааг шинжихэд:

- Байгалийн нөөц, баялагтай холбоотой заалт хамгийн олон 16, амьдрах орчин, аюулгүй байдал, амьдралын хэв маягийн 13, хэрэглээний соёлын талаарх заалт 11 байна.
- Ногоон эдийн засаг гэсэн үгээр орсон заалт 1 байна.
- Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой заалт 3, хүлэмжийн хийн холбоотой заалт 1 байна.
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагын өөрчлөлт, шинэчлэлийн талаар заалт ороогүй байна.
- Хөтөлбөр НХБ-ын үзэл баримтлал, зарчмыг баримталсан байна (Хүснэгт 14, 15).

Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг НХБ-ын зорилттой харьцуулахад:

- Стратегийн зорилтын тоо нь 1-ээр илүү, зорилтуудын зөвхөн 2 нь төстэй, бусад нь ялгаатай. Зарим зорилгодоо НХБ-ын хэд хэдэн зорилгыг оруулсан. Зарим зорилго НХБ-ын 10 гаруй зорилготой холбогдож байв. Иймээс 72 зорилгыг бүгд 227 удаа ашиглаж хөтөлбөрийг боловсруулжээ. Олон зорилгоос бүтсэн дэд зорилгыг задалж, тус бүрээр нь үр дүнг нь тоогоор, онуудаар төлөвлөөгүй.
- Гашуунсухайт-Баянхонгор, Баянхонгор-Шаргалзуут, Баянхонгор-Архангайн автозам зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалтын зорилтуудыг нилээд оруулсан байна (Монгол улсын Алсын Хараа 2050-т Гашуунсухайт-Баянхонгорын автозам тусгагдаагүй байна).
- Нөлөөллийг тооцох шаардлагатай, хэрэгжих нь эргэлзээтэй заалтууд байна.  
Тухайлбал:
  - 2.1.5-д Тусгай хамгаалалттай газар нутгийг 2023 онд нийт нутгийн 25%, 2028 онд 30% хүргэнэ гэж заасан нь 2 сая 900 мянга га, 3 сая 348 мян га

болох юм. Ийм том талбайг тусгай хамаагалалтанд авахад бэлчээр багасах, даац хэтрэх, мал аж ахуйд сөрөг нөлөөлөл учрах магадлалтай.

- 2.5-д ойжуулах ажлыг эрчимжүүлж, ой бүхий талбайг 2028 онд нийт газар нутгийн 9%-д хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ гэсэн нь хэрэгжих магадлал маш бага. Учир нь Баянхонгор аймгийн ой модоор бүрхэгдсэн талбай 298.9 мян га, энэ нь нутаг дэвсгэрийн 2.5%. 2028 онд 9% болгоно гэвэл энэ нь 1 сая 76 мян га. Энэ нь Завхан, Төв аймгийн ойн нийт талбайгаас ч том. Гэтэл төлөвлөгөөнд жил бүр 13 га нутаг дэвсгэрийг ойжуулахаар тусгажээ.

#### Хүснэгт 14. Ногоон хөгжлийн бодлогын үзэл баримтлалтай нийцтэй байдал

| НХБ-ын үзэл баримтлалын гол агуулга                   | Баянхонгор аймаг |
|---|------------------|
| 1.Байгалийн нөөц баялаг                               | 16               |
| 2.Экосистем, экосистемийн үйлчилгээ                   | 3                |
| 3.Тогтвортой хөгжил                                   | 5                |
| 4.Нийгмийн тэгш, хүртээмж-тэй байдал                  | 2                |
| 5.Ногоон эдийн засаг                                  | 1                |
| 6.Хүлэмжийн хий                                       | 1                |
| 7.Хэрэглээ  | 11               |
| 8.Өөрчлөлт, шинэчлэлт                                 | -                |
| 9.Ядуурал, ажилгүйдэл, ажлын байр                     | 5                |
| 10.Амьдрах орчин, аюулгүй байдал, амьд-ралын хэв маяг | 6                |
| Дүн   | 50               |

#### Хүснэгт 15. Ногоон хөгжлийн бодлогын зарчимд нийцтэй байдлын шинжлэл

| НХБ-ын зарчим   | Баянхонгор |
|---|------------|
| Нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглах      | 5          |
| Цэвэр дэвшилтэт технологийг дэмжих                    | 21         |
| Ногоон өсөлтийг бий болгоход иргэдийн оролцоог хангах | 5          |
| Байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх      | 5          |
| Ил тод, хариуцлагатай, хяналттай байх                 | 6          |

#### Хүснэгт 16. Ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлттэй харьцуулсан байдал

| Үзүүлэлт  | Улс  |      | Баянхонгор |      |
|---|------|------|------------|------|
|   | 2020 | 2030 | 2023       | 2028 |
| 1. Сэргээгдэх эрчим хүч                                     | 20   | 30   |            |      |
| 2. Барилгын дулааны алдагдлын бууралт                       | 20   | 40   |            |      |
| 3. Хог хаягдлын дахин боловсруулалт                         | 20   | 40   |            |      |
| 4. Ногоон хөгжилд зарцуулах зардлын ДНБ-нд эзлэх хувь       | 2    | 3    |            |      |
| 5. ШУТ-ийн судалгаанд зарцуулах зардлын ДНБ-нд эзлэх хувь   | 2    | 3    |            |      |
| 6. ЗГ-ын ногоон худалдан авалт                              | 20   | 30   |            |      |
| 7. Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ                | 25   | 30   | 25         | 30   |
| 8. БО хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгө оруулалт             | 20   | 30   |            |      |
| 9. Нийт газар нутагт ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь   | 8.5  | 9    |            | 9%   |
| 10. Баталгаат ундны усаар хангагдах хүн амын эзлэх хувь     | 80   | 90   |            |      |
| 11. Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдах хүн ам | 40   | 60   |            |      |
| 12. Ядуурлын түвшин   | 24   | 15   |            |      |

|   |    |    |  |  |
|---|----|----|--|--|
| 13. Хот суурин газрын ногоон байгууламж | 15 | 30 |  |  |
| 14. ДНБ-нд ХАА, боловс. үйлдвэрлэл      | 28 | 30 |  |  |

**Нийцтэй байдал** (хууль, бодлого, журам). Аймгийн НХХ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 4.1.2-д заасан “аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт” гэсэн ангилалд багтах дунд, урт хугацааны хөгжлийн баримт бичиг бөгөөд уг хөтөлбөрийг боловсруулах, батлуулах явц, санхүүжилт, хэрэгжилтийн хяналт зэрэг нь энэ хуулийн дагуу байх ёстой. НХХ агуулгын хувьд Ногоон хөгжлийн бодлого (НХБ, УИХ 2016)-ын үзэл баримтлал, зорилго, зорилт, шалгуур үзүүлэлттэй нийцтэй, төлөвлөх үйл ажиллагаа, бүтцийн хувьд Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам (ЗГ, 2016)-ыг баримталсан байх учиртай боловч энэ шаардлагыг бүрэн хангахгүй байна.

#### 5.1.5. Биологийн олон янз байдлыг хамгаалах бодлого, төлөвлөлт

**Хууль, бодлогын баримт бичгүүд.** Байгалийн ургамал, амьтны талаар Монгол улсад Ургамал хамгааллын тухай (2007), Байгалийн ургамлын тухай (1995, шинэчлэх төсөл 2018), Амьтны тухай (УИХ 2012) зэрэг хуулиуд, 2025 он хүртэл баримтлах Биологийн олон янз байдлын Үндэсний хөтөлбөр (БОЯБҮХ, ЗГ 2015) мөрдөгдөж байгаа бөгөөд хөтөлбөрт 4 тэргүүлэх чиглэл, 14 зорилго, 29 зорилт, 74 хүрэх үр дүнг тусгажээ. Хөтөлбөрт зааснаар бол аймаг, сумын “нутгийн захиргааны байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт хангуулах, түүнийг сайжруулахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй” аж.

НХБ-д “3.2.4. биологийн олон янз байдлын удмын санг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг тэтгэх замаар хомсдолоос сэргийлж, ашиглалтын нөөц бүрдүүлэх”, “3.1.12. байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд болон биологийн олон янз байдалд сөрөг нөлөөгүй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлэх” зэрэг зорилтууд бий.

Монгол улсын “Амьтны тухай” хуульд аймгийн засаг дарга нар болон агнуурын бүс нутгийг хариуцагчид 5 жил тутамд хариуцсан нутагтаа агнуур зохион байгуулалт хийлгэж, агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулсан байна гэж заасан байдаг тул аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт, аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө, мөн агнуурын бүс нутгийн нарийвчилсан агнуур зохион байгуулалтын тайлан, агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилттэй танилцаж, дүгнэлт, санал өгөх нь бодлогын гол баримт бичиг хуультай нийцнэ.

**Баянхонгор** аймгийн ЗДҮАХ-т ой, бэлчээрийн хортонтой тэмцэх, мод тарихаас гадна ховор амьтан ургамлыг сэргээн нутагшуулах, тарималжуулах үржүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа тусгагдсан байна.

**Захуй –Зармангийн говьд** бүртгэгдсэн шувуудын олон улсад 3 зүйл нь эмзэг, 1 зүйл ховордож болзошгүй, бүс нутгийн хэмжээнд 3 зүйл “эмзэг, 1 зүйл ховордож болзошгүй гэж үнэлэгдсэн, 1 зүйл Монголын улаан номонд тэмдэглэгдсэн, 13 зүйл CITES-ийн конвенцын хавсралтад, 16 зүйл CMS-ийн хавсралтад бүртгэгдсэн байна.

**Улаан шалын хоолойд** бүртгэгдсэн шувуудын 4 зүйл нь Монгол улсын Засгийн газрын тогтоолоор “ховор” гэж үнэлэгдсэн, 6 зүйл нь Монгол улсын улаан номонд бүртгэгдсэн, 21 зүйл нь CITES-ийн хавсралтад бүртгэгдсэн, 21 зүйл нь CMS-ийн хавсралтад бүртгэгдсэн ба олон улсын хэмжээнд ховордож болзошгүй 4 зүйл, эмзэг 6 зүйл, бүс нутгийн хэмжээнд устаж болзошгүй 2 зүйл, эмзэг 5 зүйл, ховордож болзошгүй 6 зүйл тэмдэглэв.

Үүнээс гадна бүс нутгийн хэмжээнд Улаан шалын хоолойд 3 зүйл “мэдээлэл дутмаг” гэж үнэлэгдсэн байна. Эндээс устаж болзошгүй, эмзэг зэрэг ховордлын зэрэгт бүртгэгдсэн шувуудыг хамгаалах, “мэдээлэл дутмаг” гэж үнэлэгдсэн шувуудыг судлан статусыг тодорхойлох шаардлага харагдаж буй бөгөөд төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй юм.

**Дүгнэлт:** Бодлогын нийцлийн судалгаанаас харахад амьтдын зүйлийн бүрдлийг тодорхойлох, агнуурын амьтдыг хамгаалах, зүй зохистой ашиглахтай холбоотой менежментийн төлөвлөгөөнд мониторинг хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, сайжруулах санал боловсруулах ажил нь аймгийн болон улсын хэмжээний бодлого зорилтуудтай бүрэн нийцэж байна.

#### **5.1.6. АГААР, УС, ХӨРСНИЙ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

Баянхонгор аймгийн 2017-2020 оны агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр нь 4-н зорилтын хүрээнд нийт 32 арга хэмжээ авч хэрэгжүүлснээс агаарын бохирдлыг 50%-иар бууруулах зорилт 80%, хөрсний бохирдлыг 40%-иар бууруулах зорилт 95%, усны бохирдлыг 50% бууруулах зорилт 90%-тай байна. Зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ 2019 оны байдлаар 87.5%-ийн биелэлттэй гарч байна.

Эдгээр дэд хөтөлбөрийн усны бохирдлыг 50 хувиар бууруулах зорилт нь аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 113 заалт, Ус үндэсний хөтөлбөрийн 3.1.9, УННМТ 1.8 дах заалтуудтай нийцтэй байна.

#### Хүснэгт 17. Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийн хэрэгжилт

| <b>Дэд хөтөлбөрийн зорилтууд</b>  | <b>Дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тоо</b> | <b>Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ,%</b> |
|---|---|---|
| Зорилт 1. Агаарын бохирдлыг 50 хувиар бууруулна.                          | 14  | 80  |
| Зорилт 2. Хөрсний бохирдлыг 40 хувиар бууруулна.                          | 10  | 95  |
| Зорилт 3. Усны бохирдлыг 50 хувиар бууруулна                              | 5   | 90  |
| Зорилт 4. Иргэдийн экологи, нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх | 3   | 85  |

#### **5.1.7. Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө**

Баянхонгор аймгийн нутагт хамргадах Орог нуур Түйн голын сав газар нь 17 стратегийн зорилго, 118 арга хэмжээг I үе шат 2018-2021, II үе шат 2022-2025, III үе шат 2026-2030, Бөөнцагаан нуур Байдраг голын сав газар нь 18 стратегийн зорилго 133 арга хэмжээ, Хяргас нуур - Завхан голын сав газар 5 стратегийн зорилго, 165 арга хэмжээг 1-р үе шат 2014-2017, 2-р үе шат 2018-2021, Алтайн-Өвөр говийн сав газар нь 18 стратегийн зорилго, 124 арга хэмжээг I үе шат 2019-2020, II үе шат 2021-2025, III үе шат 2026-2030 онуудад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 18. Баянхонгор аймгийн нутаг дэвсгэр хамрагдах сав газрын УННМ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө

| № | Сав газар                   | Стратегийн зорилго | Арга хэмжээ | Хугацаа                         |
|---|-----------------------------|--------------------|-------------|---------------------------------|
| 1 | Алтайн-Өвөр говь            | 18                 | 124         | 2019-2020, 2021-2025, 2026-2030 |
| 2 | Орог нуур Түйн гол          | 17                 | 118         | 2018-2021, 2022-2025, 2026-2030 |
| 3 | Бөөнцагаан нуур Байдраг гол | 18                 | 133         | 2014-2017, 2018-2021            |
| 4 | Хяргас нуур-Завхан гол      | 5                  | 165         | 2015-2017, 2018-2021            |

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт хамрагдах сав газрын УННМТ-ний нийтлэг зорилт

1. Ойг хамгаалах, нөхөн сэргээлт хийх
2. Усны эх үүсвэрийн хамгаалалтыг сайжруулах, тохижуулах
3. Хүн амыг баталгаат ундны усаар хангаж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
4. Усны хяналт шинжилгээний сүлжээг өргөтгөх
5. Сав газрын захиргааг бэхжүүлэх, үндсэн үйл ажиллагааг нь дэмжих
6. Усан сан хөв цөөрөм байгуулах
7. Усны нөөцийг бохирдох, хомсдохоос хамгаалах, арвижуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, “Ус” үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө болон Баянхонгор аймгийн нутаг хамрагдах сав газрын УННМТ-нд нийгэм, эдийн засгийн салбаруудын хөгжлийн бодлого, зориултуудтай уялдуулан Хүн амын ус, ХАА-н ус, Үйлдвэрийн ус, Хүрээлэн буй орчны ус, Сав газрын усны менежментийн орчин гэсэн 5 багц асуудал 2016-2020 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэнд

- 2017 онд Хүн амыг баталгаат ундны усаар хангах - 1,
- 2018 онд Хүн амыг баталгаат ундны усаар хангах - 2, Үерийн хамгаалалтын далан барих – 1, Усны тоо бүтгэл зохион байгуулах - 1, Усны эх үүсвэрийн хамгаалалтыг сайжруулах, тохижуулах - 1
- 2019 онд Усны эх үүсвэрийн хамгаалалтыг сайжруулах, тохижуулах – 1, Усны нөөцийн эрэл хайгуул хийх, нөөцийг баталгаажуулах – 1, 2020 онд Усны эх үүсвэрийн хамгаалалтыг сайжруулах, тохижуулах – 1, Хүн амыг баталгаат ундны усаар хангах – 2 арга хэмжээ төлөвлөсөн боловч зарим арга хэмжээний хувьд хөрөнгө, санхүү шийдэгдээгүйн улмаас хэрэгжээгүй байна.

Хүснэгт 19. ЗДҮАХ-д тусгагдсан авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

| Он   | Арга хэмжээ  | Биелэлт |
|------|--|---------|
| 2017 | Нэн тэргүүнд шаардлагатай худаг, усан сангуудад ус цэвэршүүлэгч төхөөрөмж тавих, “Ухаалаг усан сан” төсөл хэрэгжүүлж эхлэх, Гурванбулагийн сумын ундны усны эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэх | 0%      |
| 2018 | Баянхонгор сумын усан сангуудад ус цэвэршүүлэгч төхөөрөмж байрлуулж, ухаалаг усан сан төслийг хэрэгжүүлэх  | 100%    |
|      | Шинэжинст сумын төвийн иргэдийг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангах ажлын хүрээнд эрчим хүчний шугам   | 40%     |

|      |  |      |
|------|--|------|
|      | татаж, ус дамжуулах хоолой угсрах, Баянхонгор аймгийн цэвэр усны байгууламжид худаг гаргах зураг төсөв хийлгэх   |      |
|      | Өлзийт сумын 4-р багийн нутаг Намгийн голд үерийн хамгаалалтын далан барих   | 100% |
|      | Усны тоо бүртгэлийг зохион байгуулах   | 100% |
|      | Унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс тогтоож, дэглэмийг мөрдүүлэн тэмдэгжүүлэх  | 100% |
| 2019 | Булаг шандны ундаргыг хамгаалах арга хэмжээ авах   | 100% |
|      | Түйн голын болон түүний цутгал голуудын татамын зураглал хийлгэх   | 100% |
|      | Шаргалжуут рашааны нөөцийг тогтоолгох, дахин үнэлэх  | 70%  |
| 2020 | Баянхонгор аймгийн ундны усны эх үүсвэрийг хамгаалах үерийн даланг шинэчлэх  | 0%   |
|      | “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төслийн хүрээнд сумдын ундны усны мэдээллийн санг бүрдүүлж, ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах | 100% |
|      | Ус хангамжийн эх үүсвэрийг автоматжуулах   | 0%   |

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт УННМТ-ний үндсэн зорилго, зорилт авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд бага тусгагдсан байна Иймд УННМТ-д тусгагдсан арга хэмжээг аймгийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах үр дүнтэй хийж гүйцэтгэхэд хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих шаардлагатай байна.

#### 5.1.8. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Баянхонгор аймгийн ГЗБЕТ нь ойрын буюу 2005-2010, дундын буюу 2010-2015, хэтийн буюу 2015-2020 онуудад 3 үе шаттай хэрэгжиж дууссан байна. ЗДҮАХ, нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлийн 2017-2020 оны хэрэгжилтэй харьцуулахад хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт дутмаг, харьцуулах боломжгүй байна.

ГЗБЕТ-г Монгол улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль журам, тогтвортой, ногоон хөгжлийн бодлогод нийцүүлэн шинэчлэх шаардлагатай. Мөн ГЗБЕТ-д тусгагдсан арга хэмжээг А5ЖҮЧ, ЗДҮАХ төлөвлөгөөнд тусгах, үр дүнтэй хийж гүйцэтгэхэд хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих шаардлагатай байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын байгуулж байгаа орон зайн дэд бүтэц нь байгаль, нийгмийн бүх төрлийн мэдээллийг тодорхой орон зай, газар нутаг буюу нэг суурин дээр нэгтгэх, уялдуулах, ингэснээрээ аливаа зүйлийн тухайн үеийн нөхцөл байдал, өөрчлөлт хувьсал болон олон хүн, байгууллага, салбарын үйл ажиллагаа, олон төрлийн бодлого, хөтөлбөр, төсөл төлөвлөгөөний хэрэгжилтийн дүнд хүн, байгалийн орших орон зай, амьдрах эх сурвалж хэрхэн өөрчлөгдөж байгаа болон аливаа, бодлого, төлөвлөлтийн бодит нөлөө, үр дүнг гаргах, үнэлэх, мөн олон талын оролцоог хангах боломжийг олгож байна.



## 5.2. АЙМАГ, СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨТӨЛБӨР

### 5.2.1. Хөгжлийн бодлогын баримт бичгийн нийцэл

Баянхонгор аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн 2021 оны жилийн төлөвлөгөөнд дүн шинжлэл хийхэд дараах үр дүн гарсан.

**А5ЖҮЧ:** Баянхонгор аймгийн үндсэн чиглэл нь 8 бүлэг, 20 чиглэлийн 106 арга хэмжээтэй. Үндэсний нэгдмэл үнэт зүйл чиглэлээр 1 зорилго, 2 зорилт, 8 арга хэмжээ (8%), Хүний хөгжил 1 зорилго, 5 зорилт, 31 арга хэмжээ (29%), Амьдралын чанар ба дундаж давхарга 1 зорилго, 4 зорилт, 12 арга хэмжээ (11%) үүнээс газрын харилцаа 1, Эдийн засаг 1 зорилго, 2 зорилт, 15 арга хэмжээ (14%), Засаглал 1 зорилго, 2 зорилт, 8 арга хэмжээ (8%), Ногоон хөгжил 1 зорилго, 1 зорилт, 11 арга хэмжээ (10%), Амар тайван амьдрал 1 зорилго, 3 зорилт, 8 арга хэмжээ (8%), Орон нутгийн хөгжил 1 зорилго, 1 зорилт, 13 арга хэмжээ (10%) үүнээс ХАА-н 4 арга хэмжээ дэвшүүлсэн байна. Үндсэн чиглэлд тусгагдсан ногоон хөгжил, хөдөө аж ахуй, сэргээгдэх эрчим хүч, газрын харилцааны арга хэмжээг Алсын хараа 2050, Монгол Улсын үндсэн чиглэл 2021-2025-тай хэрхэн нийцэж байгаад дүн шинжлэл хийсэн. Үндсэн чиглэлд тусгагдсан ногоон хөгжил, хөдөө аж ахуй, сэргээгдэх эрчим хүч, газрын харилцааны арга хэмжээг Алсын хараа 2050, Монгол Улсын үндсэн чиглэл 2021-2025, Ногоон хөгжлийн бодлого 2014-2030-тай хэрхэн нийцэж байгаад дүн шинжлэл хийсэн.

Ногоон хөгжлийн чиглэлд Эх байгаль, анхдагч экосистем - 2, Байгалийн баялагийн үр өгөөж - 3, Үнэт баялаг ус - 6, Хөдөө аж ахуйн - 4, Газрын харилцаа - 1, сэргээгдэх эрчим хүчний - 0 нийт 16 арга хэмжээ тусгагдсанаас Алсын хараа 2050, Монгол Улсын үндсэн чиглэл 2021-2025-тай 13 арга хэмжээ буюу 81%, Ногоон хөгжлийн бодлого 2014-2030-тай 8 арга хэмжээ буюу 50% нийцэлтэй байна.

#### Хүснэгт 20. Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн нийцэл

| Чиглэл  | Зорилт, арга хэмжээ   | Алсын хараа 2050 | Улсын үндсэн чиглэл, 2021-2025 | Ногоон хөгжлийн бодлого, 2014-2030 |
|---|---|------------------|--------------------------------|------------------------------------|
| Газрын харилцаа   | 3.4. Орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | 3.6.2            | -                              | -                                  |
| Ногоон хөгжил   | <b>Эх байгаль, анхдагч экосистем</b>  |                  |                                |                                    |
|   | 6.1.1. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөнө.   | -                | 6.1.1                          | 3.2.1                              |
|   | 6.1.2. Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эхүүдийг судалж хамгаалах, урсацыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллана.  | 6.1.4            | 6.1.1                          | -                                  |
|   | <b>Байгалийн баялагийн үр өгөөж</b>   |                  |                                |                                    |
| 6.1.3. Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн | 6.2.8   | 6.2.1            | 3.6.2                          |                                    |

| Чиглэл                          | Зорилт, арга хэмжээ  | Алсын хараа 2050 | Улсын үндсэн чиглэл, 2021-2025 | Ногоон хөгжлийн бодлого, 2014-2030 |
|---------------------------------|--|------------------|--------------------------------|------------------------------------|
|                                 | эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээнэ.  |                  |                                |                                    |
|                                 | 6.1.4. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.  | 6.2.4            | 6.2.5                          | 3.2.7                              |
|                                 | 6.1.5. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж стандарт хэм хэмжээг мөрдүүлэх, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана.  | 6.2.14           | 6.2.3                          | -                                  |
|                                 | <b>Үнэт баялаг ус</b>  |                  |                                |                                    |
|                                 | 6.1.6. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах, усны бохирдол хомсдолыг бууруулж ажиллана.                                 | 6.3.5            | 6.3.1                          | -                                  |
|                                 | 6.1.7. Газрын байгалийн тогтоц, нуга, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, Байдраг голыг түшиглэн олон зориулалтаар ашиглах усан сан байгуулна.                     | 6.3.10           | 6.3.2                          | -                                  |
|                                 | 6.1.8. Усны нөөц, гидрогеологийн зураглал хийж, усны нөөц баялгийн мэдээллийн сан бүрдүүлэн усны нөөцөд тохирсон хэрэглээг хэвшүүлнэ.  | 6.3              | 6.3.4                          | 3.2.1                              |
|                                 | 6.1.9. Хүлэмжийн хийн ялгарлыг 10 хувиар бууруулна.  | 6.4.17           | 6.4.4                          | 3.1.1                              |
|                                 | 6.1.10. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна. | -                | 6.4.3                          | -                                  |
|                                 | 6.1.11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, хог хаягдлын дахин боловсруулалтын үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлнэ.   | 2.5.10           | 6.4.7                          | 3.6.4                              |
| <b>Тогтвортой хөдөө аж ахуй</b> | 8.1.10. Малын чанар, ашиг шимийг сайжруулах, малын тоог чанарт шилжүүлж "Монгол мал-2", "Монгол малчин" үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.   | -                | 8.3.4                          | -                                  |
|                                 | 8.1.11. Бэлчээр ашиглалт хамгаалалтыг сайжруулж, өнжөөж чөлөөлөх, усжуулах, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг үе шаттай зохион байгуулна.   | 6.2.12           | 8.3.3                          | 3.4.7                              |
|                                 | 8.1.12. Услалтын системийг бүрэн ажиллуулж тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулж, малын тэжээлийн ургамал тариалж дотоодын хэрэгцээг ханган, газар тариалан  | -                | 8.3.6                          | 3.1.5                              |

| Чиглэл                 | Зорилт, арга хэмжээ   | Алсын хараа 2050 | Улсын үндсэн чиглэл, 2021-2025 | Ногоон хөгжлийн бодлого, 2014-2030 |
|------------------------|---|------------------|--------------------------------|------------------------------------|
|                        | эрхлэлтийг дэмжиж төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.  |                  |                                |                                    |
|                        | 8.1.13. Малын халдварт, гол халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мал эрүүлжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж эрүүл бүс статусаа бататгана. | 8.3.4            | -                              | -                                  |
| Нийцэлтэй байдлын хувь |   | 75%              | 88%                            | 50%                                |

Баянхонгор аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө нь 5 бүлэг, 139 арга хэмжээтэй. Хэрэгжилтийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ногоон хөгжлийн арга хэмжээ Алсын хараа 2050, үндсэн чиглэл 2021-2025-тай хэрхэн нийцэж байгаад анализ хийв. Ногоон хөгжлийн чиглэлд – 21 арга хэмжээ тусгагдсанаас Алсын хараа 2050-тай – 3 (14%), Баянхонгор аймгийн үндсэн чиглэл 2021-2025 онтой - 9 (74%) арга хэмжээ нь нийцэж байна.

#### Хүснэгт 21. Баянхонгор аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний нийцэл

| Чиглэл   | Зорилт, арга хэмжээ  | Алсын хараа 2050 | Аймгийн үндсэн чиглэл, 2021-2025 |
|--|--|------------------|----------------------------------|
| Ногоон хөгжил-Эко орчин  | Баацагаан сумын Бөөнцагаан нуурыг Улсын тусгай хамгаалалтад авах, Бөөнцагаан нуурын менежментийн төлөвлөгөө боловсруулна.  | 6.3.7            | 6.1.1                            |
|  | Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, Орон нутгийн өмчит компани байгуулах, тусгай хамгаалалттай газруудын тохижуулах, сэргээн засварлах                  | -                | 6.1.1                            |
|  | Мэргэжлийн байгууллагаар аймгийн ойн менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулна   | -                | -                                |
|  | Орон нутаг өөрийн нөөц боломжоор 1 сая мод тарьж, ойн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ  | 9.2.9            | 6.1.4                            |
|  | Ойн ангид модны суулгацын дэмжлэг олгох  | -                |                                  |
|  | Зэрлэг амьтдыг хамгаалах өвс тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр зэрлэг амьтны байршил бүхий газруудад биотехникийн арга хэмжээ авах | -                | -                                |
| Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ | Байгалийн горим эвдэгдсэн бохирдсон голуудын голдиролд үзлэг хийж эвдэгдсэн хэсэгт голдирлыг шулуутгаж сэргээнэ.   | -                | -                                |
|  | Аймгийн хэмжээнд усны мэдээллийн санг боловсронгуй болгож, мэдээ мэдээллийг сайжруулж нэгдсэн мэдээллийн сантай болгох   | 6.3.8            | 6.1.8                            |
|  | Усны тухай хуулийн 17.1.4-т заасны дагуу Усны хяналтын тоо бүртгэлийг хийж баталгаажуулах  | -                | -                                |
|  | Булгийн эхийг хамгаалах, ундаргыг сэргээх, хөв байгуулах ажлыг малчид, малчдын бүлэг, нөхөрлөлийн хамтаар хийж хэрэгжүүлэх   | -                | 6.1.7                            |
|  | Баянхонгор сумын ундны усны эх үүсвэрт худаг гаргах  | -                | 6.1.8                            |

|  |            |            |
|--|------------|------------|
| Баянхонгор сумын ундны усны харуул хамгаалалт  | -          | -          |
| Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ төслийг хэрэгжүүлэх      | -          | -          |
| Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж ажиллана.  | -          | 6.1.11     |
| "Эх хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөөллийг бууруулах" төслийг хэрэгжүүлэх  | -          | -          |
| Баянхонгор сумын 4.5 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны болон дулааны шугамд шат дараатайгаар холбох                                   | -          | -          |
| Эрдэнэмандал хайрханыг моджуулж ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.  | -          | 2.5.4      |
| Баянхонгор сумын төв дундах шороон замыг асбальтон хучилттай хар зам болгож тоосжилтыг багасгах  | -          | -          |
| Эрдэнэцогт суманд Хог тээврийн автомашин нийлүүлэх   | -          | -          |
| Баянхонгор сумын хог хаягдлын цэгийг шинэчлэхэд "Цэвэр хот" ОНӨҮГ-гээр гүйцэтгүүлж байнгын ашиглагдах автомашин, тоног төхөөрөмжөөр хангах | -          | -          |
| Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх   | -          | -          |
| <b>Нийцэлтэй байдлын хувь</b>  | <b>14%</b> | <b>42%</b> |

## 5.2.2. Асуудлын шинжлэл

Баянхонгор А5ЖҮЧ, хөгжлийн жилийн төлөвлөгөөнд орох саналыг Баянхонгор аймгийн 18 сумаас нийт 56 хүн хамрагдсан, үүний 31 нь аймгийн төвөөс, бусад нь 17 сумаас нэг, хоёроороо оролцов. Саналын үр дүнг дараах хүснэгтэнд оруулав.

### Хүснэгт 22. А5ЖҮЧ, хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах санал

| Хөгжлийн төлөвлөгөөнд тусгах зүйл                      | Санал | Нийт | Нийт саналд эзлэх хувь, % |
|--|-------|------|---------------------------|
| Ажлын байр нэмэгдүүлэх                                 | 46    | 56   | 82.1                      |
| Зам, тээврийн дэд бүтэц                                | 24    | 56   | 42.8                      |
| Боловсролын үйлчилгээ                                  | 18    | 56   | 32.1                      |
| Шинэ техник, технологи нэвтрүүлэх                      | 15    | 56   | 26.8                      |
| Хүнсний үйлдвэр  | 13    | 56   | 23.2                      |
| Нийтийн аж ахуйн үйлчилгээ                             | 12    | 56   | 21.4                      |
| Нийтийн, өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах | 12    | 56   | 21.4                      |
| Малын ашиг шимийг нэмэгдүүлэх                          | 11    | 56   | 19.6                      |
| Малыг эрүүлжүүлэх                                      | 10    | 56   | 17.8                      |
| Эмнэлэгийн үйлчилгээ                                   | 9     | 56   | 16.1                      |
| Орон сууцны хангамж                                    | 9     | 56   | 16.1                      |
| Гэр, сууцны дулаалга, зуух, түлшийг сайжруулах         | 9     | 56   | 16.1                      |
| Худаг гаргах, усны хангамжийг нэмэгдүүлэх              | 9     | 56   | 16.1                      |
| Монгол төр, ахуйн арга ухааныг дэлгэрүүлэх             | 8     | 56   | 14.3                      |
| Барилгын салбар  | 5     | 56   | 8.9                       |
| Эрчим хүч  | 4     | 56   | 7.1                       |
| Үйлчилгээний салбар                                    | 4     | 56   | 7.1                       |

|  |   |    |     |
|--|---|----|-----|
| Интернетийн сүлжээ (хамралт, хурд, тариф)  | 4 | 56 | 7.1 |
| Амралт, соёлын үйлчилгээ                   | 4 | 56 | 7.1 |
| Аймаг, сумын удирдлагын үйлчилгээ          | 3 | 56 | 5.4 |
| Айл өрхийг компьютертэй Интернэттэй болгох | 3 | 56 | 5.4 |
| Багийн нутагт хөдөлгөөнт Интернэттэй болох | 3 | 56 | 5.4 |
| Уул уурхай                                 | 2 | 56 | 3.6 |
| Хүүхдийн цэцэрлэг                          | 2 | 56 | 3.6 |
| Хүнд үйлдвэр                               | 1 | 56 | 1.8 |
| Холбооны дэд бүтэц                         | 1 | 56 | 1.8 |
| ЦА: урьдчилсан мэдээг олон хоногийн өмнө   | 1 | 56 | 1.8 |
| Малын тоо нэмэгдүүлэх                      | 0 | 56 | 0   |
| Бусад                                      | 0 | 56 | 0   |

Судалгаанд оролцогчид эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцвэрийг алдагдуулахгүй байхын тулд хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж болох 12 зүйлээс хамгийн чухлыг сонгосон.


Хариултыг нэгтгэн давтагдлыг тоо, хувиар (Хүснэгт 23, Зураг 21) гаргахад хог хаягдлын менежментийг сайжруулах (80%), ногоон байгууламж нэмэгдүүлэх (64%), бэлчээр хамгаалах (34%), газрын засаглал, төлөвлөлтийг сайжруулах (32%), агаарын бохирдлыг бууруулах (32%) хэрэгтэй гэсэн саналууд эхний 5-д орж байна.

Санал асуулгад оролцогчдын олонх нь аймгийн төвөөс байсан хог хаягдал, ногоон байгууламж, газар зохион байгуулалт, агаарын бохирдол зэрэг суурин газрын асуудлаар олон санал гарсан байна. Бэлчээр хамгааллыг аймгийн төвийн хүмүүс ч чухал гэж үзсэн байна.

### Хүснэгт 23. Амьдрах орчин, экосистемийн тэнцвэрийг хангахын тулд хөгжлийн төлөвлөгөөнд тусгах санал

| Төлөвлөгөөнд тусгах зүйл                 | Санал | Нийт | Нийт саналд эзлэх % |
|--|-------|------|---------------------|
| Хог хаягдлын менежментийг сайжруулах     | 45    | 56   | 80.4                |
| Ногоон байгууламж нэмэгдүүлэх            | 36    | 56   | 64.3                |
| Бэлчээр хамгаалах                        | 19    | 56   | 33.9                |
| Газрын засаглал, төлөвлөлтийг сайжруулах | 18    | 56   | 32.1                |
| Агаарын бохирдлыг бууруулах              | 18    | 56   | 32.1                |
| Усны чанарыг сайжруулах                  | 14    | 56   | 25.0                |
| Бохир усны асуудлыг шийдэх               | 14    | 56   | 25.0                |
| Ардын уламжлалт арга ухааныг дэлгэр      | 13    | 56   | 23.2                |
| Зэрлэг амьтны амьдрах орчныг хамгаалах   | 10    | 56   | 17.9                |
| Ой, ургамал хамгаалах                    | 9     | 56   | 16.1                |
| Хөрс хамгаалах                           | 6     | 56   | 10.7                |
| Хүлэмжийн хийг бууруулах                 | 3     | 56   | 5.4                 |
| Бусад                                    | 0     | 56   | 0.0                 |

Зураг 21. Амьдрах орчин, экосистемийн тэнцвэрийг хангахын тулд хөгжлийн төлөвлөгөөнд тусгах саналын график



Нийт гарсан саналууд нь аймгийн баримтлах баримт бичгүүдэд хэрхэн тусгагдсаныг шинжилж үзэхэд:

- Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийт гарсан саналуудаас 10 санал буюу 83% нь
- Аймгийн хөгжлийн 2021 оны жилийн төлөвлөгөөнд нийт гарсан саналуудаас 6 санал буюу 50% нь (Ногоон байгууламж нэмэгдүүлэх, Газрын засаглал, төлөвлөлтийг сайжруулах, Агаарын бохирдлыг бууруулах, Усны чанарыг сайжруулах, Зэрлэг амьтны амьдрах орчныг хамгаалах, Ой, ургамал хамгаалах чиглэлээр)

Хүснэгт 24. Баянхонгор А5ЖҮЧ-д туссан санал

| № | Төлөвлөгөөнд тусгах зүйл                 | Арга хэмжээ  |
|---|--|--|
| 1 | Хог хаягдлын менежментийг сайжруулах     | 6.1.11 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, хог хаягдлын дахин боловсруулалтын үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлнэ.  |
| 2 | Ногоон байгууламж нэмэгдүүлэх            | 2.5.3 Нийт хүн амын амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай, зам бүхий эрүүл аюулгүй тохилог орчныг бүрдүүлнэ.               |
| 3 | Бэлчээр хамгаалах                        | 8.1.11 Бэлчээр ашиглалт хамгаалалтыг сайжруулж, өнжөөж чөлөөлөх, усжуулах, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг үе шаттай зохион байгуулна.  |
| 4 | Газрын засаглал, төлөвлөлтийг сайжруулах | 3.4 Орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан үйл ажиллагааг эрчимжүүлнэ.                                   |
| 5 | Агаарын бохирдлыг бууруулах              | 2.5.5 Агаар, хөрс, усны бохирдлыг үе шаттайгаар бууруулах арга хэмжээ авч ажиллах, иргэдийн оролцоог хангах, хандлагыг өөрчлөх чиглэлээр олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтарч ажиллана. |
| 6 | Усны чанарыг сайжруулах                  | 2.5.5 Агаар, хөрс, усны бохирдлыг үе шаттайгаар бууруулах арга хэмжээ авч ажиллах, иргэдийн оролцоог хангах, хандлагыг өөрчлөх чиглэлээр олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтарч ажиллана. |
|   |  | 6.1.2 Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эхүүдийг судалж хамгаалах, урсцыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллана.   |
|   |  | 6.1.6 Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн  |

| №  | Төлөвлөгөөнд тусгах зүйл                 | Арга хэмжээ   |
|----|--|---|
|    |  | хэрэгжилтийг сайжруулах, усны бохирдол хомсдолыг бууруулж ажиллана.<br>6.1.8 Усны нөөц, гидрогеологийн зураглал хийж, усны нөөц баялгийн мэдээллийн сан бүрдүүлэн усны нөөцөд тохирсон хэрэглээг хэвшүүлнэ. |
| 7  | Бохир усны асуудлыг шийдэх               | 8.1.5 Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах, усны бохирдол хомсдолыг бууруулж ажиллана.                                   |
| 8  | Ардын уламжлалт арга ухааныг дэлгэрүүлэх | -   |
| 9  | Зэрлэг амьтны амьдрах орчныг хамгаалах   | -   |
| 10 | Ой, ургамал хамгаалах                    | 6.1.4 Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.  |
| 11 | Хөрс хамгаалах                           | 6.1.3 Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээнэ.  |
| 12 | Хүлэмжийн хийг бууруулах                 | 6.1.9 Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээнэ.  |

## 6. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ

### Дүгнэлт

- Баянхонгор аймгийн хүний хөгжлийн индекс нь 2019 онд өмнө оноос 1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2018 он хүртэл хүн амын дундаж наслалт улсын дунджаас доогуур, шилжилт хөдөлгөөний улмаас боловсролын индекс жил бүр буурсан, ажлын байрны дутагдалтай, ажилгүйдэл ихтэй, хүн амын орлого 2015 оны төвшнөөс буурсан байна.
- Баянхонгор аймгийн ДНБ-ийг хөдөө аж ахуй 43.1%, аж үйлдвэр 26%, үйлчилгээний салбар 30.8%-ийг бүрдүүлж байна. ДНБ нь 2003-2019 оны хооронд алгуур өсөлттэй байсан хэдий ч 2009-2010 онд буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь 2008 онд дэлхийн дахинд эдийн засгийн хямрал нүүрлэсэн, мөн 2009-2010 оны өвөл Монгол орон даяар болсон томоохон зудын улмаас 15 аймгийн 80 сум гамшгийн, 18 аймгийн 95 сум зудын байдалд орж, нийт 10.2 сая мал хорогдсон нь ДНБ-ний бууралтын гол хүчин зүйл болсон байна. Иймд аймаг, сумдын хэмжээнд мах, дайвар бүтээгдэх, арьс шир, ноос, ноолуур, хөөвөр, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл, жимс жимсгэнэ, хүсний ногоо, тэжээлийн ургамал тариалалтыг хөгжүүлж, ажил эрхлэлтийг нэмэгдсэнээр ДНБ, ХХИ өсөх төлөвтэй байна.
- ДНБ-ийг бүрдүүлж буй ХАА, аж үйлдвэр, үйлчилгээний салбарын үйл ажиллагааг бодлогоор дэмжих замаар хэмжээг ДНБ-ийг нэмэгдүүлэх;
- Баянхонгор аймгийн ЗДҮАХ-ийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2017-2020 оны хугацаанд жилд дунджаар 82% биелэлттэй байна. Эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй зорилт, арга хэмжээнүүдийн ихэнх нь 2017 оны хэрэгжилт байна. Уг арга хэмжээнүүд нь улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн байна. Хэрэгжилт удаашралтай, үр дүнгүй байгаа нь хөрөнгө санхүүгийн эх үүсвэр хүрэлцээгүй, тооцоо судалгаа дутуу хийж арга хэмжээг төлөвлөсөнтэй холбоотой байна. Иймд авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг үе шат бүрд тоон болон чанарын үзүүлэлтээр гаргах, хөрөнгө санхүүг урьдчилсан байдлаар төлөвлөх шаардлагатай.
- Баянхонгор аймгийн 2017-2020 оны агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр нь 4-н зорилтын хүрээнд нийт 32 арга хэмжээ авч хэрэгжүүлснээс агаарын бохирдлыг 50%-иар бууруулах зорилт 80%, хөрсний бохирдлыг 40%-иар бууруулах зорилт 95%, усны бохирдлыг 50% бууруулах зорилт 90%-тай байна. Зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нийт 87.5%-ийн биелэлттэй гарсан байна.
  - Агаарын бохирдлыг 50%-иар бууруулах зорилтын хүрээнд цахилгаан халаалтыг шийдэж сольсон, айл өрхүүдийн тоолуурыг шинэчлэн, өрхөд зориулсан эрчим хүчний хэмнэлттэй халаалт, дулаалгын бүтээгдэхүүн үйлчилгээг бууруулсан ажлууд хийгдсэн боловч хэдий хэр хэмжээгээр агаарын бохирдлыг бууруулсан үзүүлэлтийг тоон үзүүлэлтээр гаргах нь дутмаг байна.
  - хөрсний бохирдлыг 40%-иар бууруулах зорилтын хүрээнд газрын бүрхэвчийн хог хаягдлыг цэвэрлэж, жорлонгоо өөрчилье гэсэн арга хэмжээг зохион байгуулж 95% биелэлттэй байна.



- усны бохирдлыг 50% бууруулах зорилтын хүрээнд 1 булгийн эхийг хамгаалж, усан сан бүхий газрыг тэмдэгжүүлж, авто угаалгын газруудыг байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэх санал санаачилгыг гаргаж ажлаад 95%-тай гэж дүгнэсэн байна.
- ЗДҮАХ-т УННМТ-ний үндсэн зорилго, зорилт авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд бага туссан байна. Иймд УННМТ-д тусгагдсан арга хэмжээг А5ЖҮЧ, ЗДҮАХ, төлөвлөгөөнд тусгах үр дүнтэй хийж гүйцэтгэхэд хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих шаардлагатай байна.
- ГЗБЕТ-г Монгол улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль журам, тогтвортой, ногоон хөгжлийн бодлогод нийцүүлэн шинэчлэх шаардлагатай. ГЗБЕТ-д тусгагдсан арга хэмжээг А5ЖҮЧ, ЗДҮАХ төлөвлөгөөнд тусгах, үр дүнтэй хийж гүйцэтгэхэд хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих шаардлагатай байна.
- Үндсэн чиглэл болон хөгжлийн төлөвлөгөөнд орох саналыг агуулгын хувьд авч үзэхэд Баянхонгор аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд 10 санал, Аймгийн хөгжлийн 2021 оны жилийн төлөвлөгөөнд 5 санал тус тус тусгагдсан байна. Нийтлэг тусгагдсан санал нь Ногоон байгууламж нэмэгдүүлэх, Газрын засаглал, төлөвлөлтийг сайжруулах, Агаарын бохирдлыг бууруулах, Усны чанарыг сайжруулах, Зэрлэг амьтны амьдрах орчныг хамгаалах, Ой, ургамал хамгаалах чиглэлийн асуудлууд байна.
- Малын тоо толгой, ашиг шим нь бэлчээр, цаг агаарын байдлаас шууд хамаардаг тул татварын хэмжээг тогтооход үүнийг харгалзаж үзвэл зохилтой. Энэ талаар хуулинд заагаагүй хэдий ч малын тоо бүртгэл, бэлчээрийн фотомониторингийн мэдээг хиймэл дагуулын мэдээгээр тодорхойлдог ургамалжилт, биомасс, нийт цэвэр бүтээгдэхүүний мэдээтэй хам боловсруулан татварын хэмжээг тогтооход ашиглаж болох юм. Бэлчээр хамгаалал, ашиглалт, малын тоо толгойн татварын талаар санал болгож байгаа арга ухаан, хэрэгслийг сум, багийн нутаг, бэлчээр ашиглалтын хэсэг, малчдын бүлгийн түвшинд хэрэгжүүлж болох бөгөөд зарим жишээг ENSURE төслийн аймаг, сум, бэлчээр ашиглах хэсгийн жишээн дээр гаргасан болно. Аймаг, сумын хөдөө аж ахуй, газар зохион байгуулалт, байгаль орчин, ус, цаг уурын мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулан нэвтрүүлэх боломжтой;
- Ой түүний дагалт баялаг, байгалийн ургамал, амьтны нөөцийг зохистой ашиглахад нутгийн иргэд дээр түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг төлөвшүүлж, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх;
- Байгалийн нөөц ашигласны татвар, төлбөр, ногоон зээл, технологийн шинэчлэлийн хөрөнгө оруулалт, карбон худалдаа зэргийг ногоон хөгжлийн хөрөнгө оруулалт, санхүүгийн хөшүүрэг болгон ашиглах;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс олсон орлогын хувь хэмжээг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны дагуу ус, ан амьтан, байгалийн ургамал, ойг хамгаалах ажилд зарцуулах, хөрс, бэлчээрийн үзүүлэлтүүдийг ашиглан экосистемийн үйлчилгээний төлбөрийг шинэчлэн, ялгавартайгаар тогтоох хэрэгтэй (хамрагдах аймгуудын байгалийн нөөц, экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ өндөр боловч түүнээс олж байгаа байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого маш бага байсан);
- Аялал жуулчлалын гол нөөц болох унаган байгаль орчноо уг хэвээр нь хадгалан дэлхий нийтээр баримталж буй тогтвортой хөгжлийн бодлогод нийцүүлэн зөв

бодлого, төлөвлөлт, менежментийн дагуу байгалийн нөөц, түүх соёлын өв, дурсгалт газруудаа түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэн эдийн засгийн хөшүүрэг болгох;

### **Санал, Зөвлөмж**

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахдаа дараах асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай:

1. Нөхцөл байдлын шинжлэл: Энэ үе шатанд нөхцөл байдлыг шинжихэд “асуудал-шалтгаан-үр дагавар”, хувьсал, өөрчлөлтийн шинжлэл, хэрэгцээт байдлын үнэлгээ хийх, шалгуур үзүүлэлт, үндэсний болон бүс нутгийн хөгжлийн зорилго, зорилтыг үндэслэн аймаг, сумын зорилтот түвшинг эхний байдлаар гаргах;
2. Бодлогын хувилбар: Нөхцөл байдлын шинжилгээг хийгээд дууссаны дараа тухайн хийсэн шинжилгээний үр дүнд хэд хэдэн бодлогын хувилбар гаргах ёстой. Үүнийг гаргахдаа ирээдүйн төсөөлөл, шинжлэл хийх юм. Хөгжлийн загвар, төсөөлөл, нөлөө, үр дүн, нөөц, санхүүгийн хэмжээ, эх үүсвэрүүдийг таамагласан байх;
3. Урьдчилсан үнэлгээ, тооцоолол: Бодлогын хувилбарууд дээр урьдчилсан үнэлгээ, тооцоолол хийх явцад нөлөөлөл, аюул, эмзэг байдал, эрсдэлийг үнэлэх, мөн хүний хөгжил, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, хөгжлийн бодлоготой уялдах байдлын үнэлгээ, үр ашгийн тооцооны үнэлгээг хийх;
4. Бодлогын сонголт: Үнэлгээ тооцоотой хэд хэдэн боломжит бодлогын хувилбаруудаас, хувилбарын шинжлэл хийж зөв, цаашид хэрэгжих бодлогын сонголтыг энэ үе шатанд хийх;
5. Бодлогын зорилт, зорилго: Энэ үе шатанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийн арга хэмжээ, зорилго, зорилт, эрэмбэ дараалал, үе шатыг тодорхой болгон шинжлэл, оновчлол, тодотгох үйл явцыг сайн хийж өгөх;
6. Үйл ажиллагаа, хөрөнгө, санхүү: Бодлогын баримт бичигт тусгагдсан хийгдэхээр төлөвлөж буй арга хэмжээнүүдийн Шалгуур үзүүлэлт, Суурь үзүүлэлт, Зорилтот түвшин, Үйл ажиллагаа, Хөрөнгө оруулалт санхүүжилтын эх үүсвэрийг тодорхой болгосноор бодлогын баримт бичгийн сүүлийн хувилбар гарч батлуулах хэлэлцүүлэх ажлыг хийх;

Бодлогын сонголт, Бодлогын зорилт, зорилго, Үйл ажиллагаа, хөрөнгө санхүүгийн гэсэн сүүлийн 3 үе шатанд шинжлэл, оновчлол, тодотголыг үе шат болгонд хянаж байхыг зөвлөж байна.

### **Хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтийн талаарх зөвлөмж**

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, гүйцэтгэлийг гаргах, хяналт-шинжилгээ хийх талаар дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Гүйцэтгэл гаргах
  - Тухайн дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтэд заасан чанарын болон тоон үзүүлэлт тус бүрээр хүрэх түвшинтэй нь харьцуулан гаргаж байх;
  - Гүйцэтгэл гаргахад тухайн дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлын гүйцэтгэлийг бичих бөгөөд хэрэгжилтийн явц болон гарсан үр

- дүн, зарцуулсан төсөв санхүүг эх үүсвэрийн хамт үнэн зөв, бодитой тайлагнах;
- Гүйцэтгэлийг гаргахад үйл явцыг тайлагнах байдлыг эрс багасгаж, үр дүнг тайлагнах;
  - Хэрэгжилтийн үнэлгээ хувийг Засгийн газрын 2017 оны 89-р тогтоолоор батлагдсан журмын 6.2 дахь хэсэгт заасан үнэлгээний арга зүй, аргачлалын дагуу тооцох;
2. Хяналт-шинжилгээ
- Хэлтсийн бодлого хариуцсан мэргэжилтнүүд дээрх асуудлуудыг бүрэн хангаж, биелэлтийг харъяа хэлтсийн даргаар хянуулан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст заасан хугацаанд нь хүргүүлж байх;
  - Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс биелэлттэй холбоотой нэмэлт мэдээлэл, баримт материал шаардсан тохиолдолд холбогдох албан тушаалтнууд тухай бүр нь хурдан шуурхай, үнэн зөв, чанартай гаргаж заасан хугацаанд ирүүлж байх;
  - “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4.1-д заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нэгж ажиллуулах;
  - Тухайн байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж байгаа хэдий ч журмын дагуу ажилдаггүй, нэр төдий ажилладаг байдлыг таслан зогсоож, хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх;
  - Хэрэгжүүлэгч байгууллагаас гаргаж байгаа бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг гаргаж ирүүлэхдээ тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж болон удирдлагаар хянуулан баталгаажуулж ирүүлэх;
3. Төлөвлөлт, хэрэгжилт
- Зорилт, арга хэмжээг төлөвлөгдсөн цаг хугацаанд нь хэрэгжүүлэх, тооцоо судалгаа дутуу, хэрэгжих боломжгүй арга хэмжээ төлөвлөхгүй байх;
  - Үнэлгээгээр үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай нь тодорхой болсон зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах, эрчимжүүлэх талаар салбар хариуцсан мэргэжилтэн, байгууллагын дарга зэрэг холбогдох албан тушаалтнууд тодорхой ажил зохион байгуулж, ажлыг эрчимжүүлэх;